



**МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН
2021 ОНЫ ҮР ДҮНГИЙН
ТАЙЛАН**

АГУУЛГА

Монгол улс дахь НҮБ-ын удирдлагын баг	4
Бүлэг 1: Улс орны нөхцөл байдал	5
Бүлэг 2: НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээг хэрэгжүүлэх замаар үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын хөгжлийн системээс үзүүлсэн дэмжлэг	12
2.1 НҮБ-ын ХТХ-ний тэргүүлэх чиглэлүүд	12
2.2 Хөгжлийн тусламжийн хүрээний тэргүүлэх чиглэлүүд, үр дүнгийн зорилтууд, үр дүн	12
2.2.1 НҮБ-ын ХТХ-ний үр дүнгийн зорилт нэг: хүртээмжтэй өсөлт, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих	16
2.2.2 НҮБ-ын ХТХ-ний үр дүнгийн зорилт хоёр: Нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш, хүртээмжтэй нийгмийн үйлчилгээг бий болгох	25
2.2.3 НҮБ-ын ХТХ-ний үр дүнгийн зорилт гурав: олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хариуцлагыг бэхжүүлэх	34
2.2.4 2021 онд тулгарсан сорилт бэрхшээлүүд	39
2.3 2030 оны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилт, түншлэлийг дэмжих	40
2.4 НҮБ-ын хамтын ажиллагааны үр дүн: НҮБ-ын үйл ажиллагааны харилцан уялдаа үр дүн, нөлөө	44
2.5 Үнэлгээ сургамж	46
2.5.1 Үнэлгээний гол үр дүн, дүгнэлт	46
2.5.2 Зөвлөмж	47
2.6 Санхүүжилт, хөрөнгийн татан төвлөрүүлэлт	49
2.6.1 Санхүүжилт, зарцуулалт	49
2.7.2 Хөрөнгийн татан төвлөрүүлэлт	50
Бүлэг 3: НҮБ-ын удирдлагын багийн ирэх жилийн тэргүүлэх чиглэл	51
Хавсралт	52
Товчилсон үгсийн жагсаалт	52

ӨМНӨХ ҮГ



Монгол Улс дахь НҮБ-ын 2017-2021 оны Хөгжлийн тусламжийн хүрээ (ХТХ)-г хэрэгжүүлээд хэдийнээ таван жил өнгөрч байна. Энэхүү НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газартай хамтран бүтээсэн ололт амжилтаа дүгнэн хуваалцахад таатай байна.

2021 он бол Хөгжлийн тусламжийн хүрээг хэрэгжүүлсэн сүүлийн жил байсны зэрэгцээ Монгол Улс НҮБ-д Бүрэн эрхт гишүүнээр элссэний 60 жилийн ой тохиосноороо НҮБ болон Монгол Улсын Засгийн газрын аль алины хувьд онцгой жил байлаа.

НҮБ-ын Удирдлагын баг нь ХТХ-ний хэрэгжилтийн үнэлгээг амжилттай зохион байгуулсны зэрэгцээ НҮБ-аас 2023-2027 онд Монгол Улсад хэрэгжүүлэх НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБ-ын ТХХАХ)-г боловсруулах суурь үндэслэл болох шинэ үеийн Монгол Улсын Төлөв байдлын шинжилгээг ч мөн хийлээ. НҮБ-ын ТХХАХ нь тус улсад 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор НҮБ-ын зүгээс хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөрүүдийг төлөвлөн бодит ажил болгох үндсэн баримт бичиг байх бөгөөд уг баримт бичгийг боловсруулж саяхан дуусаад байна.

ХТХ-ний хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн үнэлгээний дүгнэлтэд НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээний үндсэн гурван зорилтын хүрээнд дэвшүүлсэн арга хэмжээнүүд амжилттай хэрэгжсэн төдийгүй НҮБ нь үйл ажиллагаагаа тус улсад шинээр бий болсон нөхцөл байдал, онцгой байдлын үеийн урьдчилан тооцоолоогүй хэрэгцээ шаардлагад нийцсэн хариу арга хэмжээг авахад чиглүүлж ирснийг онцлон тэмдэглэсэн. Үүний хамгийн тод жишээ бол сүүлийн хоёр жилийн хугацаанд КОВИД-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн НҮБ-ын хамтарсан үйл ажиллагаа юм.

Цөөн хэдэн жишээг дурдвал, НҮБ-ын зүгээс хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт 489081 хүүхдийг зайны сургалтад хамруулж, тус улсын нийт хүн амын 43 хувийг вакцинаар хангаж, 1726 эрүүл мэндийн байгууллага, 8610 эрүүл мэндийн ажилтанд дэмжлэг үзүүлэх зэргээр бодитой ажлуудыг хийлээ. Үүний үр дүнд Монгол Улс зорилтот бүлгийн хүн амынхаа 80 гаруй хувийг вакцинжуулалтад хамруулж, хоёроос дээш тооны тун вакцин хийлгэсэн хүн амынхаа вакцинжуулалтаар тэргүүлэгч орнуудын нэг болсон. Энэ нь хөгжиж буй улс орны хувьд том амжил билээ.

Түүнчлэн НҮБ-ын Удирдлагын баг нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх зохицуулалтын механизмыг боловсронгуй болгох замаар ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн стратегийн түвшний зохицуулалттай дэмжлэгийг Монгол Улсын Засгийн газарт үзүүлж байна.

Иймээс миний бие эдгээр ололт амжилтаар бахархаж байгаа төдийгүй энэхүү тайланд танилцуулж байгаадаа сэтгэл хангалуун байна. Эдгээр бүх амжилтын ард баттай зогсож байгаа НҮБ-ын Удирдлагын баг болон НҮБ-ын ажилтнуудад чин сэтгэлээсээ талархал илэрхийлье. Үүний нэгэн адил энэ хугацаанд нягт хамтран, дэмжин ажиллаж байсан бүх түншүүддээ, ялангуяа Монгол Улсын Засгийн газарт гүн талархал илэрхийлье.

Тапан Мишра

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин зохицуулагч

МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГ

СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИД

СУУРИН БУС ТӨЛӨӨЛӨГЧИД



Монгол дахь НҮБ

Тапан Мишра
НҮБ-ын Суурин
зохицуулагч



ХХААБ

Винод Ахужа
Суурин төлөөлөгч



НҮБХХ

**Илейн
М. Конкиевич**
Суурин төлөөлөгч



НҮБХАС

Каори Ишикава
Тэргүүн



НҮБХС

**Эваристе
Коуаси-Комлан**
Суурин төлөөлөгч



ДЭМБ

Сергей Диордица
Суурин төлөөлөгч



ОУАЭА

**Рафаел Мариано
Гросси**
Ерөнхий захирал



ОУХБ

Чанхи Ли
Олон улсын Хөдөлмөрийн
байгууллагын БНХАУ,
Монгол Улсыг хариуцсан
товчооны захирал



ОУШХБ

**Жьюзеппе
Крочетти**
Олон улсын шилжилт
ходолгооний байгууллагын
БНХАУ болон Монгол улс
дахь салбарын тэргүүн



НҮББОХ

Мүүн Шреста
НҮБ-ын Байгаль орчны
хөтөлбөрийн Ази, Номхон
далайн бүсийн
Хөтөлбөрийн мэргэжилтэн



НҮБАНДЭЗНК

**Баасанжавын
Ганболд**
НҮБ-ын Ази Номхон далайн
Эдийн засаг, нийгмийн
комиссын Зүүн, Зүүн-Хойд
Азийн салбар төвийн захирал



ЮНЕСКО

Шабхаз Хан
ЮНЕСКО-ийн Бээжин
дэх төлөөлөгчийн газрын
захирал, Суурин төлөөлөгч



НҮБАУХБ

Лаксман Перера
НҮБ-ын Хабитат
байгууллагын Япон улс
дахь салбарын Хүний
суурьшлын асуудал
хариуцсан мэргэжилтэн



НҮБ-ХАБИТАТ

Стивен Б. Каргбо
НҮБ-ын Аж үйлдвэр
хогслийн байгууллагын
БНХАУ, БНАСАУ болон
Монгол Улсыг хавсран
суугаа Суурин төлөөлөгч

МОНГОЛ УЛС ДАХЬ НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН СИСТЕМИЙН ГОЛ ТҮНШҮҮД

2021 онд Монгол Улс дахь НҮБ нь Монгол Улсын Засгийн газар болон хөгжлийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшил зэрэг олон салбарын байгууллагуудтай хамтран ажиллах бат бэх түншлэлээ үргэлжлүүлсээр ирсэн. Монгол Улс дахь НҮБ нь Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах

боломжийг олгож байгаа улс орнуудын засгийн газрын байгууллагууд, олон улсын тусгай сангууд, олон улсын төрийн бус байгууллагууд, дотоодын төрийн бус байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшлийнхэн зэрэг бүх талуудын техникийн болоод санхүүгийн тусламж дэмжлэгийг онцлон тэмдэглэж гүнээ талархаж байна .

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД

МУ-ын Засгийн газрын харьяа түнш байгууллага, агентлагууд	
1	УИХ-ын Тамгын газар
2	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
3	Шадар сайдын ажлын алба
4	Барилга, хот байгуулалтын яам
5	Боловсрол, шинжлэх ухааны яам
6	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
7	Сангийн яам
8	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
9	Гадаад харилцааны яам
10	Эрүүл мэндийн яам
11	Хууль зүй, дотоод хэргийн яам
12	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
13	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
14	Зам, тээврийн хөгжлийн яам
15	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
16	Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар
17	Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар
18	Төрийн албаны зөвлөл
19	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
20	Стандарт, хэмжил зүйн газар
21	Үндэсний хөгжлийн газар
22	Онцгой байдлын ерөнхий газар
23	Хүний эрхийн үндэсний комисс
24	Үндэсний статистикийн хороо
25	Жендерийн үндэсний хороо
26	Олон улсын Ус хөтөлбөрийн Засгийн газар хоорондын зөвлөл
27	Хавдар судлалын үндэсний төв
28	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
29	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
30	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
31	Орхон аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
32	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
33	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори
34	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн цөмийн оношзүйн тасаг
35	Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар
36	Аймгуудын засаг даргын тамгын газар

Үндэсний төрийн бус байгууллагууд	
1	Монголын банкны холбоо
2	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
3	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
4	Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо
5	Монголын хүүхдийн эмч нарын холбоо
6	Хөгжлийн шийдэл ТББ
7	МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ
8	Шинэ нийгмийн эрүүл мэнд
9	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн
10	Иргэний боловсролын төв
11	Залуучуудын зохистой хөдөлмөрийн дэмжих үндэсний сүлжээ
12	Ойн эзэд
13	Хүйсийн тэгш эрхийн төв
14	Гэр хорооллын зураглал төв

Олон улсын байгууллагууд/Улс орнуудын хоёр талт хамтын ажиллагааны агентлагууд	
1	Азийн хөгжлийн банк
2	Орогнол хүсэгчид, дүрвэгсдийн асуудлаарх бүс нутгийн санаачлага
3	Орогнол хүсэгчдийг хүсэлтийг хүлээн авах Холбооны агентлаг
4	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
5	Даян дэлхийн ногоон хөгжлийн институт
6	Олон улсын байгаль орчны технологийн төв
7	Бельги улс дахь ОУШХБ
8	БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны агентлаг

Олон улсын төрийн бус байгууллага	
1	Адвентист хөгжил тусалцааны агентлаг
2	Алтны бичил уурхайн зөвлөл
3	Азийн сан
4	Хүүхдийн биеэ үнэлэлт, худалдаалах гэмт хэргийг таслан зогсооё
5	Мерси Корпс
6	Монголын улаан загалмайн нийгэмлэг
7	Норвегийн дүрвэгчдийн зөвлөл
8	Пипл Ин Нийд
9	Хүүхдийг ивээх сан
10	Үр удмын сан
11	Олон улсын аврах хороо
12	Дэлхийн зөн
13	Дэлхийн байгаль хамгаалах сан



Эрдэм шинжилгээний байгууллагууд	
1	Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн
2	Мал эмнэлэгийн хүрээлэн
3	“Маастриктийн их сургууль - НҮБ-ын Их Сургууль Мэрит”
4	Хөдөө аж ахуйн их сургууль
5	Анагаахын шинжлэх ухааны их сургууль
6	МУИС
7	МУИС-ийн Цөмийн судалгааны төв
8	Стокгольмын байгаль орчны инстит

Зураг 1: НҮБ-ын агентлагуудтай хамтран ажилласан хэрэгжүүлэгч байгууллагууд

САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

Улс орнуудын Засгийн газар	
1	Монгол улсын Засгийн газар
2	Австрали улсын Гадаад хэрэг, худалдааны яам
3	ЕХ-ны ОУ-ын хамтын ажиллагааны хөгжлийн Ерөнхий захирлын алба
4	Европын Комиссын Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
5	Европын комисс
6	Европын холбооны төлөөлөгчийн газар
7	ХБНГУ-ын Эрүүл мэндийн яам
8	Австрали улсын Засгийн газар
9	Канад улсын Засгийн газар
10	Дани улсын Засгийн газар
11	Япон улсын Засгийн газар
12	Люксембургийн их гүнт улсын Засгийн газар
13	Монако улсын Засгийн газар
14	Норвеги улсын Засгийн газар
15	Нидерланд улсын Засгийн газар
16	БНСУ-ын Засгийн газар
17	ОХУ-ын Засгийн газар
18	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант улсын Засгийн газар
19	АНУ-ын засгийн газар
20	ХБНГУ-ын Байгаль орчны яамны олон улсын цаг уурын санаачилга
21	JTIP Тэтгэлгийн сан
22	КОЙКА Олон улсын байгууллага
23	Уур амьсгалын үйл ажиллагааг сайжруулах багц
24	RPTC
25	Дэлхийн хөгжлийн түншлэлийн Сөүл бодлогын төв
26	SEPA
27	Шведийн Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг
28	Швейцарын хөгжлийн агентлаг
29	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн яам
30	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг

Олон улсын төрийн бус байгууллагууд	
1	НҮБ-ын Хүүхдийн сангийн Канад дахь Үндэсний хороо
2	БНСУ-ын хүүхдийн сан
3	Гави Вакцины холбоо
4	НҮБ-ын Хүүхдийн сангийн Итали дахь Үндэсний хороо
5	НҮБ-ын Хүүхдийн сангийн Япон дахь Үндэсний хороо
6	Япон улсын сайн дурын хандив
7	БНСУ-ын олон улсын эрүүл мэндийн сан
8	НҮБ-ын Хүүхдийн сангийн БНСУ дахь Үндэсний хороо


9	НҮБ-ын Хүүхдийн сангийн Люксембургийн Их Гүнт Улс дахь Үндэсний хороо
10	НҮБ-ын Хүүхдийн сангийн Нидерландын Хант Улс дахь Үндэсний хороо
11	НҮБ-ын Хүүхдийн сан: ЕХ-ын эрсдэлийн бууруулах сан болон Дэлхийн хүнсний хөтөлбөр/АНУ-ын Хөгжлийн агентлаг
12	НҮБ-ын Хүүхдийн сангийн Саудын Араб дахь Үндэсний хороо
13	НҮБ-ын Хүүхдийн сангийн Англи дахь Үндэсний хороо
14	Дэлхийн нөөцийн хүрээлэн

Глобал төрөлжсөн сангууд	
1	Дасан зохицлын сан
2	НҮБ-ын ХХ-ийн Биологийн олон янз байдлыг санхүүжүүлэх итгэлцлийн сан
3	Онцгой байдлын хариу арга хэмжээний төв сан
4	НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн хэлтсийн Хөгжлийн данс
5	НҮБ-ын ХХААБ-ын Техникийн хамтын ажиллагааны хөтөлбөр
6	Даян дэлхийн боловсролын сан
7	Даян дэлхийн жендерийн сан
8	Даян дэлхийн эрүүл мэндийн сан
9	Даян дэлхийн хүнсний шим тэжээлийн сан
10	Боловсролын төлөөх даян дэлхийн түншлэл
11	Даян дэлхийн байгаль орчны сан
12	Даян дэлхийн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн сан
13	Уур амьсгалын ногоон сан
14	Даян дэлхийн хүүхэд хамгаалах сан
15	Даян дэлхийн нийгмийн хүртээмжийн сан
16	Техникийн хамтын ажиллагааны байнгын хөтөлбөр
17	ОУШХБ-ын Хөгжлийн сан
18	Тогтвортой хөгжлийн зорилтууд-сан
19	Монреал протоколыг хэрэгжүүлэгч олон талт сан
20	Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийн Олон талт итгэлцлийн сан
21	ПАИ Сан
22	Олон улсын химийг бодисын менежментийн стратегийн арга
23	НҮБ-ын КОВИД-19 ОТТИС
24	НҮБ-ын ХХ-ийн шуурхай санхүүжилтийн хөтөлбөр
25	НҮБ-ын Хүүхдийн сангийн EAPRO яаралтай тусламж
26	НҮБ-ын ХС Хүмүүнлэгийн сан
27	НҮБ-ын Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хөтөлбөр ба олон талт түншүүдийн итгэлцлийн сан

Олон улсын санхүүгийн байгууллагууд	
1	Азийн хөгжлийн банк
2	Дэлхийн банк

Хувийн хэвшил/ бусад	
1	Говь Оюу хөгжлийг дэмжих сан
2	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг устгах сан
3	Оюу толгой компани
4	PSFR
5	Бусад сан

Зураг 2: НҮБ-ын агентлагуудтай хамтран ажилласан санхүүжүүлэгч байгууллагууд



МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН 2021 ОНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН ЦӨӨН ҮГЭЭР

НҮБ-аас Монгол Улсын тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмэр



- 191** төсөл, хөтөлбөрийг
- 84** хэрэгжүүлэгч байгууллагууд
- 21** Улаанбаатар хот болон 21 аймагт хэрэгжүүлсэн.

Ковид-19 цар тахалтай тэмцэхэд НҮБ-ын үзүүлсэн дэмжлэг

1.4 сая хүнд буюу нийт хүн амын **43%** КОВИД-19-ийн вакцинжуулалт

301,068 Жирэмсэн эхийн эрүүл мэндийг хамгаалахад

60,507 хүнд Бусад халдварт өвчний эсрэг вакцинжуулалт

8610 Эрүүл мэндийн ажилтан

1726 Эрүүл мэндийн байгууллага


2.5 сая хүнд КОВИД-19-ийн талаарх мэдээлэл

820,793 хүнд ундны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжаа сайжруулахад

489,081 хүүхдийг алсын зайны сургалтад хамрагдахад

Гадаадын **17** улсад гацсан эмзэг бүлгийн **518** монгол иргэдийг эх орондоо эргэж ирэхэд

НҮБ-аас хэрэгжүүлсэн үйл ажиллагаа Тогтвортой хөгжлийн зорилго тус бүрээр, 2017-2021 оны байдлаар



Зураг 2.1.1: ТХЗ-ын тодорхой зорилгуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн НҮБ-ын төсөл хөтөлбөрүүд

МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2021 онд Монгол Улс КОВИД-19 цар тахлын улмаас улс төр, эдийн засаг, нийгмийн олон сорилттой тулгарсан. 2020 оны 11-р сард КОВИД-19 цар тахлын халдвар хүн амын дунд тархаж эхэлснээс хойш Монгол Улсад КОВИД-19 халдварын хэд хэдэн давалгаа гарч, тэдгээрээс сэргийлэх зорилгоор хөл хорио, хязгаарлалтын хатуу арга хэмжээ авч ирсэн.

2021 оны 1-р сарын сүүлчээр Улаанбаатар хотод КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн эсрэг засгийн газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагааг эсэргүүцсэн олон нийтийн тайван жагсаал цуглаан болсон нь Ерөнхий сайд огцорч, Засгийн газрын бүрэлдэхүүн өөрчлөгдөхөд хүргэсэн. 2021 оны 6-р сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд эрх баригч намаас нэр дэвшигч үнэмлэхүй ялалт байгуулснаар 1990 оноос хойш тус улсад хоёр дахь удаагаа эрх баригч МАН-ын төлөөлөл төрийн бүх удирдах дээд албан тушаалын дийлэнхийг бүрдүүлэх болсон. 2020 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн эрх мэдэл тодорхой хэмжээгээр хязгаарлагдсан хэдий ч УИХ-д МАН дийлэнх олонхи болсон энэ нөхцөлд, түүний ялалт нь бодлогын залгамж чанарыг улам бүр баталгаажуулсан.

Монгол Улс Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд¹ төгрөгийн цогц төлөвлөгөөг 2021 оны 2-р сард баталсан нь тус улсад коронавируст халдварын (КОВИД-19) цар тахлын эсрэг вакцинжуулалтын аяныг эрчимжүүлэхэд дэмжлэг болсон. 2021 оны эцсийн байдлаар Монгол Улсын нийт хүн амын 70 орчим хувь нь бүрэн вакцинжуулалтад хамрагдсанаар тус улс нь хүн амаа хамгийн олноор бүрэн вакцинжуулалтад хамруулсан дэлхийн тэргүүлэх орнуудын нэг болж байна. 2021-2023 онд зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалах, хүн амаа орон сууцжуулах, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарууд, уул уурхайн бус салбарын экспортыг дэмжих зорилгоор Эдийн засгийн сэргээх багц хөтөлбөрийг Монголбанк (ДНБ-ий

27 орчим хувь) санхүүжүүлсэн. Засгийн газраас эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах зорилгоор КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн өргөн хүрээг хамарсан тусламжийн багцыг олгосны зэрэгцээ хэдийнээ хэрэгжиж байсан хүүхдийн мөнгөний хэмжээг нэмэгдүүлсэн нь үндэсний хэмжээнд 2018 онд 28,4 хувь байсан ядуурлын түвшинг 2020 онд 0,6 хувь пунктээр буюу 27.8 хувь болж буурахад ихээхэн нөлөөлсөн.²

Эрүүл мэндийн салбарын хямрал, ядуурлаас урьдчилан сэргийлэхэд эдгээр эрүүл мэнд, нийгмийн хамгааллын цогц хариу арга хэмжээ нэн шаардлагатай байсан хэдий ч нөгөө талаас төсвийн орон зайд нэмэлт дарамт учруулсны зэрэгцээ өрийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, тогтвортой хөгжилд шаардагдах хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэрийг бууруулсан. 2020 онд сүүлийн арав гаруй жилийн хугацаанд тохиосон анхны томоохон уналттайгаа тулгарсан Монголын эдийн засаг 2021 оны эхний хагас жилд төсөөлж байснаас хавьгүй илүү өсөлттэй байсан нь гол төлөв эрдэс баялгийн экспорт, дэлхийн эдийн засгийн сэргэлт эрчимжсэн, уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) болон хувийн хөрөнгө оруулалт сэргэж байгаа зэргийг харуулж байна. Гэвч БНХАУ удаа дараалан хил гаалиа хааж байсан нь нүүрсний экспорт, олборлолт эрс буурч, ДНБ-ий бодит өсөлт эхний төсөөлөл болон цар тахлын өмнөх буюу 2019 оны түвшингээс нилээд доогуур буюу 1.4 хувь болж буурахад нөлөөлсөн. Төсвийн алдагдал ДНБ-ий 3.2 хувьтай тэнцэхээр болж 2020 оны түвшнээсээ эрс буурсан нь гадаад зээлийг төрийн сангаас санхүүжүүлэхэд хүргэсэн. 2021 оны дунд үе гэхэд Засгийн газрын өр 27 их наяд төгрөгт хүрсэн нь 2021 оны бодит ДНБ-тэй тэнцэж байна.

Дэлхий нийтэд өрнөж буй чиг хандлагын нэгэн адил КОВИД-19 цар тахлыг даван туулах стратегийн хүрээнд Монгол Улсад төрийн 181 үйлчилгээг үзүүлэх “Цахим-Монгол” дижитал платформыг хөгжүүлэн нэвтрүүлж, оюутан

¹ Монгол Банк. (2021 оны 12 дугаар сарын 31) 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн Монголбанкны албан ханшаар тооцвол 10 их наяд төгрөг нь 3,5 тэрбум ам.доллартай тэнцэж байна. Үзэх <https://www.mongolbank.mn/eng/dblistofficialdailyrate.aspx?vYear=2021&vMonth=12&vDay=31>

² Үндэсний Статистикийн Хороо болон Дэлхийн Банк (2020) Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа. Үзэх <https://www.worldbank.org/en/news/press-release/2021/12/30/mongolia-s-2020-poverty-rate-estimated-at-27-8-percent>

сурагчдад цахимаар суралцах боломж нөхцөлийг бүрдүүлэх үйл явцыг түргэтгэсэн. Мөн УИХ-аас ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чухал дэмжлэг болох хэд хэдэн хууль тогтоомжийг баталсан бөгөөд Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийг баталсанаар Монгол Улс Ази тивдээ хүний эрхийн асуудлууд, зөрчлийг арилгах чиглэлээр ажилладаг хүмүүсийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн анхны орон болсон.

Цар тахлын дэгдэлтээс сэргийлж тогтоосон хөл хорио, хязгаарлалтын үеэр эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол нэмэгдсэнтэй холбогдуулан засгийн газрын зүгээс нийгмийн үйлчилгээ хүргэх болон хууль сахиулах арга хэмжээг бэхжүүлсэн.

Монгол Улс нь Ази-Номхон далайн бүсийн Худалдааны хэлэлцээрт нэгдсэн, БНХАУ-Монгол Улс-ОХУ-ын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг түргэтгэсэн зэрэг нь ложистикийн үйл ажиллагааг болоод худалдааг хөнгөвчлөхөд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, улмаар тус улс нь олон улсын дамжин өнгөрөх тээврийн гол зангилаа болох зэрэгт

хувь нэмэр оруулах асар их боломжийг нээж өгсөн юм. Монгол Улсын Засгийн газраас боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, ногоон хөгжил, төрийн бүтээмжийг иргэд, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоотойгоор хөгжүүлэх чиглэлээр бүтцийн өөрчлөлт хийхээр тусгасан Шинэ сэргэлтийн бодлогыг боловсруулан 2021 оны 12-р сард баталсан.

Мөн 2021 он Монгол Улсад ТХЗ-ыг хэрэгжүүлэх жил болсон. Шинэ Ерөнхий сайд Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд НҮБ-ын системийн байгууллагууд, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөллийг оруулж шинэчлэн зохион байгуулсан. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 10-р сард Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд дүгнэлт өгч, эрчимжүүлэх зорилгоор Тогтвортой хөгжлийн зорилго-Үндэсний дээд түвшний анхдугаар чуулга уулзалт зохион байгуулж, Монгол Улс 2030 он хүртэл Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх амлалтаа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөлийг байгуулснаа зарласан.



НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН СИСТЕМЭЭС ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ


2 БҮЛЭГ

2.1 НҮБ-ЫН ХТХ-НИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

НҮБ-ын 2017-2022 оны Хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБ-ын ХТХ) хэрэгжиж эхлээд тав дахь жилдээ ороод байна. Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагууд 2017 оноос хойш Монгол Улсыг 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор стратегийн болоод үндсэн нэгжүүдийн нийт 191 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлээд байна. НҮБ-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн дийлэнх нь ядуурал, өлсгөлөнг бууруулах, эрүүл мэндийг сайжруулах, зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хуурай газар нутгийн менежментийг сайжруулах зэрэг асуудалд чиглэгдсэн. Түүнчлэн 2.1.1 дүгээр зурагт үзүүлсэнчлэн НҮБ нь аж үйлдвэржилт, инноваци, дэд бүтцийг сайжруулах, тэгш бус байдлыг бууруулах, хот, суурьшлын бүсүүдийг хүнд ээлтэй тогтвортой хөгжүүлэх, энх тайван, шударга ёсыг бий болгох, түншлэлийг бэхжүүлэх зэрэгт ч хувь нэмэр оруулсан.

Сүүлийн таван жилийн хугацаанд НҮБ-ын системийн байгууллагууд нийт 191.3 сая ам.долларын хөрөнгийг татан төвлөрүүлснээс 163.1 сая ам.долларын санхүүжилтийг 21 аймаг, нийслэлд 84 хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн 191 төсөл, хөтөлбөрт зарцуулсан байна (Зураг 2.1.2.)


Хэрэгжүүлэгч байгууллагууд



Зураг 2.1.3: НҮБ-ын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд

- Засгийн газар
- Дотоодын ТББ
- ОУ-ын ТББ
- ОУБ, Гадаад улс орны Засгийн газар
- Эрдэм шинжилгээний байгууллагууд

НҮБ-ын нийт санхүүжилт, 2017-2021 сая ам. доллар



Зураг 2.1.2: НҮБ-ын төсөл хөтөлбөрийн нийт санхүүжилт, зарцуулалт

Монгол Улсын Засгийн газар нь НҮБ-тай нягт хамтран ажиллахын зэрэгцээ хамтарсан санхүүжилтээ алгуур нэмэгдүүлж өнгөрсөн таван жилийн хугацаанд ойролцоогоор 8 сая ам.долларын хөрөнгийн хамтарсан санхүүжилт хийсэн байна. Өнөөг хүртэл гадаад улс орны төрийн 32 байгууллага, олон улсын 28 тусгай сан, төрийн бус 15 байгууллага, хувийн хэвшлийн 4 байгууллага, Олон улсын санхүүгийн 2 байгууллага тус тус НҮБ-ын төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ирсэн.

НҮБ-ын нийт төсөл хөтөлбөрийг үр дүнгийн гурван зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн. Үүнд: Монгол Улсад 1) хүртээмжтэй өсөлт, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих; 2) нийгмийн хамгааллыг өргөжүүлж, чанартай, эрх тэгш нийгмийн үйлчилгээний ашиглалтыг нэмэгдүүлэх; 3) хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэхийг дэмжиж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх зэрэг болно.

Үр дүнгийн зорилт 1-ийн хүрээнд НҮБ нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, тусгай хамгаалалттай газар нутаг, ойн сангийн хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан. Энэ хүрээнд хамтаар дэвшүүлсэн зорилтуудынхаа шалгуур үзүүлэлтүүдийг бид биелүүлсэн. Боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртгийн (MVA) ДНБ-д эзлэх хувь хэмжээ төлөвлөсний дагуу аажмаар нэмэгдэж, ажилгүйдлийн түвшинг зорилтот түвшинд хүргэж чадсан. Гэсэн хэдий ч сүүлийн 5 жилийн хугацаанд асар их хүчин чармайлт гаргасан боловч сэргээгдэх эрчим хүчний нийт хэрэглээнд эзлэх хувь, ойн сан бүхий газар нутгийн хувь хэмжээ төдийлэн өсөхгүй, гамшгаас үүдсэн хохирол, ядуурлын түвшинд амьдарч байгаа хүмүүсийн хувь зэрэг үзүүлэлтүүд буурахгүй удааширсан хэвээр байгаа нь ажиглагдаж байна (Зураг 2.1.4-ийг үзнэ үү).

Үр дүнгийн зорилт 1-ийн шалгуур үзүүлэлт

Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах Явц: Биелсэн	Тусгай хамгаалалтын бүсийн нийт талбайд эзлэх хувь Явц: Биелсэн
Үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн ДНБ-д эзлэх хувь Явц: Төлөвлөсний дагуу	Ажилгүйдлийн түвшин Явц: Төлөвлөсний дагуу
Үндэсний эрчим хүч дэх сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь Явц: Төлөвлөсний дагуу	Нийт талбайд ойн сан бүхий газрын эзлэх хувь Явц: Төлөвлөсний дагуу
Гамшгаас үүдэлтэй эдийн засгийн алдагдал Явц: Ухарсан	Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой хүмүүсийн эзлэх хувь Явц: Ухарсан

Зураг 2.1.4: Үр дүнгийн зорилт 1-ийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт

Үр дүнгийн зорилт 2-ын хүрээнд НҮБ нь сайжруулсан ус хэрэглэдэг хүн амын хувийн жинг нэмэгдүүлэх, Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоог дэмжих, 15-60 насандаа нас барах магадлалтай хүн амын тоог бууруулах, өсвөр насныхны төрөлтийг бууруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр бодитой дэмжлэг үзүүллээ. Эдгээр үзүүлэлтүүдийн зорилтот түвшний хэрэгжилтийг Зураг 2.1.5-д үзүүллээ





Үр дүнгийн зорилт 2-ын шалгуур үзүүлэлт

Сайжруулсан усны эх үүсвэрийг ашигладаг хүн амын хувь Явц: Биелсэн	Шинэчилсэн эсвэл шинээр баталсан эрүүл мэндийн бодлого, стратеги, төлөвлөгөөний тоо Явц: Биелсэн
Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх стратегийг баталж хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо Явц: Биелсэн	15-60 насандаа нас барах магадлал буурсан байх Явц: Биелсэн
Улсын нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувь Явц: Биелсэн	1000 хүнд ногдох өсвөр үеийнхний төрөлт (15-19 нас). Явц: Биелсэн
Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хамрагдалт Явц: Биелсэн	Эрүүл мэнд, суралцах чадвар, бие сэтгэл санааны хувьд хэвийн байгаа хамгийн ядуу бүлгийн 5 хүртэлх насны хүүхдүүдийн хувь Явц: Биелсэн
Сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг хүн амын хувь Явц: Төлөвлөсний дагуу	Жирэмсний үед 6-аас доошгүй удаа жирэмсний хяналтын үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь Явц: Төлөвлөсний дагуу
Цусны даралт ихсэх, чихрийн шижин өвчний шинжилгээнд хамрагдсан 40-өөс дээш насны хүн амын хувь Явц: Төлөвлөсний дагуу	5 хүртэлх насны хүүхдийн өсөлтийн хоцрогдол Явц: Төлөвлөсний дагуу
13-17 насны илүүдэл жинтэй сурагчдын тархалт Явц: Төлөвлөсний дагуу	

Зураг 2.1.5: Үр дүнгийн зорилт 2-ын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт

Үр дүнгийн зорилт 3-ын хүрээнд, НҮБ нь Монгол Улсад Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг), Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (ЭАБХУК)-ийн зөвлөмжүүд, хүний эрхийн бусад механизмын зөвлөмжийг хэрэгжүүлэх, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн эсрэг хэд хэдэн хууль тогтоомжийг шинэчлэн батлах, шийдвэр гаргах түвшинд залуу сонгогчид, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх чиглэлд бодитой дэмжлэгийг үзүүллээ. Эдгээр үзүүлэлтүүдийн зорилтот түвшний хэрэгжилтийг Зураг 2.1.6-д үзүүллээ.

Үр дүнгийн зорилт 3-ын шалгуур үзүүлэлт

 <p>15-24 насны залуучуудын дунд тэмбүүгийн өвчлөлийн түвшин 10 000 тутамд</p> <p>Явц: Ухарсан</p>	 <p>Хамгийн ядуу бүлгийн хүүхдүүдийн бага, дунд боловсролд хамрагдалтын хувь</p> <p>Явц: Ухарсан</p>
 <p>Хамгийн ядуу бүлгийн 36-39 сартай бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй хүүхдүүдийн хувь</p> <p>Явц: Ухарсан</p>	 <p>Нийгмийн даатгалын тогтолцоонд шимтгэл төлж буй эдийн засгийн идэвхтэй хүн амын хувь</p> <p>Явц: Ухарсан</p>

Зураг 2.1.6: Үр дүнгийн зорилт 3-ын үзүүлэлтүүдийн биелэлт

КОВИД-19 цар тахлын дэгдэлт эхэлсэн эхний жилд засгийн газрын бүтцэд өөрчлөлт орж, цар тахалтай тэмцэх стратеги боловсруулж, цар тахлын уршгаар үүсэн бий болсон сөрөг нөлөөллийг бууруулах хүчин чармайлтууд гаргаж байсан тэр үетэй харьцуулахад цар тахлын хоёр дахь жилд тус улсад эрс өөрчлөлтүүд гарсны зэрэгцээ тэдгээрийн шууд үр дүн нь ч ажиглагдаж байна.

НҮБ-ын системийн байгууллагууд нь хамтын ажиллагаагаа амжилттай өрнүүлж, хамтарсан үр дүнд хүрэхийн төлөө ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Бизнесийн үйл ажиллагааг илүү үр ашигтай хөгжүүлэхийн тулд Захиргааны удирдлагын баг нь ажиллагчдын цаг, хүчийг илүү үр дүнтэйгээр ашиглах, худалдан авалтын ажиллагаанд зарцуулах хугацааг богиносгох замаар захиргааны зардлыг бууруулах зорилгоор хэд хэдэн төрлийн урт хугацааны хамтарсан гэрээ, хэлэлцээрийг байгуулж Бизнесийн үйл ажиллагааны стратегийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Түүнчлэн НҮБ нь Монгол Улсын Засгийн газартай стратегийн түвшинд нягт хамтран ажиллаж байна. НҮБ-ын зүгээс санаачилгатай ажилласны үр дүнд Монгол Улсын Засгийн газар Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл (ТХҮЗ)-ийг шинэчлэн байгуулсан билээ. Тус Зөвлөлийн бүрэлдэхүүнд НҮБ-ын төлөөлөл анх удаа орсон нь тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн төлөө Монгол Улсын Засгийн газартай стратегийн түвшинд улам илүү хамтран ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлсэн. Монгол Улсын Засгийн газраас ТХЗ болон “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх дунд хугацааны 10 жилийн сэдэвчилсэн хөтөлбөрүүдийг боловсруулж, батлах үйл ажиллагаанд НҮБ-аас зохицуулалттай дэмжлэг үзүүлж ажилласан.

НҮБ-ын Удирдлагын баг нь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон чиглэлээр мэдээлэл харилцаа, нөлөөллийн хамтын ажиллагаагаа зохицуулан үргэлжлүүлж байна.

2021 он бол НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБ-ын ХТХ)-г хэрэгжүүлэх сүүлийн жил учир НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн. Энэхүү үнэлгээний зөвлөмжийн дагуу авах хариу арга хэмжээг удирдлагын зүгээс тодорхойлж ойрын жилүүдэд хэрэгжүүлэх болно.

2.2 ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖИЙН ХҮРЭЭНИЙ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД, ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТУУД, ҮР ДҮН



ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 1:

ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ



14

НҮБ-ын системийн
байгууллага



78.5

сая ам.доллар



113

төсөл, хөтөлбөр



59

түнш
байгууллагууд



Тогтвортой хөгжлийг
дэмжих хууль эрх зүй,
бодлогын орчныг
бүрдүүлэхэд үзүүлсэн
НҮБ-ын дэмжлэг



Үндэсний хөгжлийн бодлого
төлөвлөлт, төсвийн
төлөвлөлтийн **эрх зүйн
орчныг сайжруулах**



- **Генетик нөөцийн** тухай хууль
- **Таримал ургамлын үр, сортын** тухай хууль
- **Ургамал хамгааллын** тухай хууль



Хөгжлийн бодлого төлөвлөлт,
төсвийн төлөвлөлт, төсөл
хөтөлбөрийн санхүүжилт,
хэрэгжилтэд **ТХЗ-ыг тус
чиглэлээрх хамтын
ажиллагаа**



2022 оны улсын
төсвийн төлөвлөлтөд
залуучуудын санал
бодлыг тусгасан.



Өсвөрийн парламент
хөтөлбөрт оролцсон
хүүхэд залуус бодлого
боловсруулагчдад уур
амьсгалын өөрчлөлтийн
асуудлаар **дуу
хоолойгоо хүргэсэн.**



Үр дүнгийн зорилт 1-ийн хүрээнд



Хүлэмжийн хийн
ялгарал буурсан

11.3%

(Зорилтот түвшинд хүрсэн)




Үндэсний эрчим хүчний бүтцэд
эзлэх сэргээгдэх эрчим хүчний
хувь нэмэгдсэн

4%



Ойн сан бүхий газрын
эзлэх хувь (сая га)

7.8%



Тусгай хамгаалалттай
газрын эзлэх хувь

20.6%

(Зорилтот түвшинд хүрсэн)



Гамшгаас үүдэлтэй эдийн
засгийн хохирол

108.2

тэрбум төгрөг



Ажилгүйдлийн түвшин
(хүйсээр)

7.3% **7%** 6.7%
(үндэсний
хэмжээнд)



Эдийн засгийг төрөлжүүлэхэд
чиглэсэн хүртээмжтэй,
тогтвортой үйлдвэржилт
(Үйлдвэрлэлийн нэмүү өртгийн
ДНБ-д эзлэх хувь) (төлөвлөсний дагуу)

9.2 %

(төлөвлөсний дагуу)



Ядуурлын түвшин

28.4%

27.2% (хот),
30.8% (хөдөө),
38% (хүүхэд)

Нийслэлийн хэмжээнд үерийн хамгаалалтыг сайжруулах чиглэлээр:



221.9 га

талбайд үерийн
хамгаалалт, далан



3419

айл өрхийн хашааг
болзошгүй үерээс
хамгаалах



5

Үерийн хамгаалалтын
далангийн барилга
байгууламж

Үр дүнгийн зорилт 1-ийн хэрэгжилтэд хувь
нэмэр оруулсан НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд:



Food and Agriculture
Organization of the
United Nations



IAEA



International
Labour
Organization



UN
environment
programme



IOM
UN MIGRATION



World Health
Organization
Representative Office
for Mongolia



UNIDO



UN-HABITAT
FOR A BETTER URBAN FUTURE



UNESCO



unicef
for every child



UN
DP



UNITED NATIONS
ESCAP
Economic and Social Commission for Asia and the Pacific



WFP
wfp.org



UNITED NATIONS
Office for Outer Space Affairs

Үр дүнгийн зорилт: 2021 он гэхэд ядуу болон эмзэг бүлгийн хүн амын гамшгийн эрсдэлийг даван туулах чадвар нэмэгдэж, хүртээмжтэй өсөлт, эрүүл экологийн тогтолцооны үр шимийг эдэлнэ.

Монгол Улсын хүртээмжтэй, тогтвортой хөгжилд шаардагдах хууль эрх зүйн болоод бодлогын орчинг бүрдүүлэх, институцийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр НҮБ-ын зүгээс техникийн дэмжлэг үзүүлсээр ирсэн. ХТХ хэрэгжих хугацаанд НҮБ-ын системийн 14 байгууллага нь хэрэгжүүлэгч 59 түнш байгууллагуудын хамтаар тус улсын хэмжээнд 113 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд нийт 78.5 сая ам.долларын хөрөнгийн санхүүжилт хийжээ. Эдгээр төсөл хөтөлбөрүүд нь нийт 18 аймаг, нийслэл Улаанбаатар хотод хэрэгжсэн. Нийт санхүүжилт нь Тогтвортой хөгжлийн 15 зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн байна.

НҮБ-ын төсөл хөтөлбөрүүд Үр дүнгийн зорилт 1-ийн хүрээнд Тогтвортой хөгжлийн дараах зорилгуудын хэрэгжилтэд хувь нэмэр оруулж байна.

- 1 ЯДУУРЛЫГ УСТГАХ
- 2 ӨЛСГӨЛӨГ ЗОГСООХ
- 3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ
- 5 ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ
- 6 ҮНДЭНЬ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ
- 7 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ
- 8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
- 9 ҮЙЛДЭВЭРЖИЛТ, ИННОВАЦИ, ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
- 10 ТЭГШ БҮС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ
- 11 ЗЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРЛОЦООГ ДЭМЖИХ
- 12 ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ ҮЙЛДЭВЭРЖИЛТИЙГ ДЭМЖИХ
- 13 УУР АМЬСТАЛЫН ӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨГ БАГАСТАХ
- 15 ХУУРАЙ ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙГ ХАМГААЛАХ
- 16 ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЕСЫГ ЦОЦГООХ
- 17 ХӨГЖЛИЙН ТӨЛӨХ ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ



Хадлан. © ХХААБ /Батзаяа

Үр дүнгийн зорилт 1-ийн хүрээнд, НҮБ-ын төсөл хөтөлбөрүүд Монгол Улсын үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлт, төсвийн төлөвлөлтийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, тус улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн тэлэх зэрэг чиглэлээр тодорхой дэмжлэг үзүүлснийг ХТХ-ний хөндлөнгийн үнэлгээний баг онцлон тэмдэглэсэн.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар Генетик нөөцийн тухай хуулийг боловсруулж, 2021 оны 12-р сард УИХ-аар батлуулсан. Уг хуулиар Монгол Улсад анх удаа Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаралтай генетик нөөц болон тэдгээртэй холбоотой уламжлалт мэдлэгийг судлах, бүртгэх, хадгалж хамгаалах, ашиглах эрх зүйн механизмыг бүрдүүлж өгсөн. Энэ хууль нь биотехнологийн

судалгаа, хөгжүүлэлтээр дамжуулан генетик нөөцийг ашигласнаас үүдэх үр шимийг хүртэхтэй холбоотой асуудлыг мөн зохицуулна. Түүнчлэн НҮБ-ын техникийн туслалцаатайгаар Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, УИХ-аар 2021 онд батлуулсан нь таримал ургамлын үрийн үйлдвэрлэл, баталгаат үр болон хөрөнгө оруулалттай хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тариаланчдын орлого, ашгийг нэмэгдүүлэхэд том хувь нэмэр оруулсан. Мөн Ургамал хамгааллын тухай хуулийг Ургамал хамгааллын олон улсын конвенц болон холбогдох стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажилд дэмжлэг үзүүлсэн.

Үр дүн 1.1.1 ТХЗ-той уялдуулсан хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, стратеги, төлөвлөгөөг боловсруулах; ингэхдээ ядуурлыг бууруулах, хүртээмжтэй өсөлт, эдийн засгийг төрөлжүүлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд эрсдлийг даван туулахад бэлтгэлтэй байх нөхцөлийг бүрдүүлэх зэргийг тэргүүлэх чиглэлээ болгох;

НҮБ нь үндэсний түншүүдтэйгээ хамтран тус улсын үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, төсвийн төлөвлөлт, төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилтэд ТХЗ-ыг тусгах чиглэлээр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж ирсэн. Хөгжлийн төлөвлөлтийн босоо, хэвтээ уялдааг хангаж төлөвлөлтийн баримт бичгийн нэгдмэл шинжийг төлөвшүүлэх зорилгоор үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг ашиглан 2021 онд ойрын болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүд, тэр дундаа Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2022 оны хөтөлбөр, 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн зорилтот долоон хөтөлбөрийг боловсруулах ажлыг НҮБ-ын техникийн тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн.

Түүнчлэн нотолгоонд суурилж бодлого боловсруулахыг дэмжих зорилгоор макро эдийн засгийн загварчлал, микро-симуляцийн загвар ашиглан бодлогын хэд хэдэн хувилбарыг боловсруулж тэдгээрийн эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр дагаварт дүн шинжилгээ хийхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн.

НҮБ-ын техникийн туслалцаатайгаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулсан. Түүнчлэн 2021 оны 4-р


сард нийтлэгдсэн НҮБ-ын Хариуцлагатай банкны бизнесийн зарчмуудын хэрэгжилтийн талаарх Голомт Банкны анхны тайланг боловсруулахад НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн.

ТХЗ-ын бодлогын орчныг улам бэхжүүлж, 2021 онд Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратегийн анхны төсөл, Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөө, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөө, барилга байгууламжийн норм дүрмийг шинэчлэх (эмнэлгүүдэд онцгой анхаарал хандуулж, хүний эрүүл мэнд, нийгмийн сайн сайхны төлөө нийтийн барилга байгууламжийн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг сайжруулах), Шинжлэх ухаан, технологийн мастер төлөвлөгөөг хянан шинэчлэх зэрэг стратегийн хэд хэдэн баримт бичгийг боловсруулж батлуулахад дэмжлэг үзүүлсэн.

Тухайлбал, бодлого шийдвэр гаргах түвшинд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны улсын төсвийн төлөвлөгөөг задлан шинжилж залуучуудын хөгжилд чиглэсэн төсвийн хуваарилалтад үнэлгээ хийж үрдүнг Залуучуудын хөгжлийн үндэсний форум дээр хэлэлцсэн нь анх удаа залуучуудын санал бодлыг улсын төсвийн төлөвлөлтөд тусгах боломж олгосон. Хүүхэд залуусын хамтын ажиллагааг дэмжих, тэдний үзэл бодол, оролцоог шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилго бүхий Өсвөрийн парламент хөтөлбөр нь хүүхэд залууст байгаль орчны талаарх үзэл бодлоо хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр дамжуулан илэрхийлэх, төр засгийн эрх баригчид, УИХ-ын гишүүдтэй нүүр тулан уулзаж ярилцах орон зай, боломжийг бүрдүүлж өгсөн.

НҮБ-ын Нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг

Эрсдэлтэй бүлгийн хүн амд зориулсан макро бодлого



Төсвийн бодлого



Хөдөлмөрийн зах зээлийн бодлого хүнсний аюулгүй байдлын үнэлгээг оролцуулсан



Нийгэм эдийн засгийн бодлого, хөдөлмөр эрхлэлтийг оролцуулсан



Ядуурлын түвшинг тооцох, ТХЗ-ын хэрэгжилтэд гарч буй өөрчлөлт, КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөлөлд хяналт шинжилгээ хийх үндэсний чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн НҮБ-аас үзүүлэх дэмжлэгийн хүрээнд Их өгөгдөл ашиглаж хийсэн КОВИД-19 цар тахлын үеийн Ядуурал, тэгш бус байдлын судалгаа, Хүүхдийн олон хэмжээст, давхацсан гачигдлын хоёр дах удаагийн үндэсний судалгаа, Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа+ (ОУБТС+), Ургамлын эрүүл ахуйн төлөв байдлын судалгаа, Монгол Улсын Хүнсний тогтолцооны үнэлгээ зэрэг хэд хэдэн судалгаа шинжилгээний ажлыг хийж тус улсын үндэсний хэмжээний мэдээллийн санг баяжуулж, хяналт шинжилгээний тогтолцоог бэхжүүлж хүүхдийн олон хэмжээст ядуурлын түвшинг тодорхойлсон болно.

Үр дүн 1.1.2 - Монгол орны онцлогт тохирсон, ард иргэдийн оролцоонд тулгуурласан уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох, түүний нөлөөллийг бууруулах арга хандлагыг нэвтрүүлэх;


НҮБ-ын зүгээс Монгол Улсын Засгийн газраас явуулж буй уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ байгаль орчныг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулж байна. Биологийн төрөл зүйлийн гол бүс нутгууд дахь тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 1,096,604,6 га болж нэмэгдсэн. Цаашлаад заган болон бореал тайгын ойг хамгаалснаар хэр хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах тооцоог шинэчилсэн. 2021-2025 онд Ойн тогтвортой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж 20,000 га бореал тайгын ойн санг хамгаалснаар ойрын арван таван жилийн хугацаанд 3,040,800 тCO₂-экв хүлэмжийн хийн ялгарлыг шингээж бууруулах тооцоо гарч байна.

Хүлэмжийн хийн тооллогын хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын системийг мета мэдээллийн санг бий болгож мэдээлэл хангамжийн удирдамжийг дэмжих зорилгоор шинэчилсэн бөгөөд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын -ийн Ил тод байдлын өргөжүүлсэн тогтолцоог дэмжих цахим платформ, тоо мэдээллийг хадгалах ХТБ-ын мэдээллийн санг байгуулсан. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбарын Ил тод байдлын өргөтгөсөн тогтолцооны тайланг бэлтгэх институтцийн зохицуулалтыг сайжруулсан. Хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, арилгах, бууруулах үйл ажиллагааг явуулах чадвар; уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал,

дасан зохицохтой холбоотой үйл ажиллагаа зэргийг НҮБ-ын техникийн туслалцаатайгаар бэхжүүлсэн. Хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор НҮБ-ын зүгээс хог хаягдлын салбарын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүллээ.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшиг нь тус улсын хүн амын шилжин нүүдэллэх шалтгааны нэг болж байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан оторлон нүүдэллэж буй хүн амд нийгмийн үйлчилгээ, мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байна. Цар тахлын халдвар дэгдэлтийн үед оторлон нүүж шилжсэн хүмүүсийн цар тахлаас урьдчилан сэргийлэх мэдээлэл авах боломж мөн адил хязгаарлагдаж улам бүр эмзэг байдалд орсноор тэдний халдвар авах эрсдэл нэмэгдэж байв. Иймээс отроор нүүдэллэж яваа малчдыг буюу уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан шилжин нүүдэллэж байгаа хүмүүсийг хамгаалах зорилгоор Монголын Үндэсний олон нийтийн радиогийн нэвтрүүлэгтэй хамтран “КОВИД-19” цар тахлын асуудлаар өдөр тутмын радио нэвтрүүлэг зохион байгуулахад НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн.

Монгол гэрийн халаалт, дулаалгын ЧИП/CHIP багцыг зохион бүтээх зэрэг зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр хөдөөгийн зорилтот хүн амын амьдрах орчин, ялангуяа дотоод орчны агаарын чанар, тав тух (хог, тоосжилт, тортог багатай) сайжирсан бөгөөд эдгээр хөтөлбөрүүдэд нийт 266 өрхийн 958 хүн (эрэгтэй 476 эрэгтэй, эмэгтэй 482) хамрагдсаны зэрэгцээ Өрхийн орлогыг нэмэгдүүлэх төлөвлөгөө төслийн хүрээнд 227 малчны бүлэгт дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, агаарын бохирдлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих зэрэг Уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны асуудлаар өндөр түвшний хэлэлцүүлэг зохион байгуулахад нь Монгол Улсын Засгийн газарт НҮБ-ын зүгээс дэмжлэг үзүүллээ. НҮБ нь ундны усны аюулгүй байдал ялангуяа усны хэмжээ, чанартай холбоотой ТХЗ-ыг хэрэгжүүлэх чиглэлээр үндэсний түнш байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Гүний усны үзүүлэлтүүд, тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийх үндэсний чадавхийг бэхжүүлсэн.



Дулаалгын ЧИП багцтай болсны үр дүнд гэрийн орчмын агаар сайжраад зогсохгүй ээж хүүхдүүддээ илүү цаг зарцуулах боломжтой болж байна. НҮБ-ын Хүүхдийн сан

Монгол гэрийн халаалт, дулаалгын ЧИП багц төсөлд хамрагдсан өрхүүдийн хувьд дулаан тав тухтай орчинд амьдрах боломжтой боллоо. Улмаар, төсөл нь нүүрс, үнс, тоос зэрэг орчны бохирдлыг бууруулахад төдийгүй өрхийн гишүүдийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлж байна. ЧИП багцаар гэрийнхээ халаалтыг шийдсэн ээжүүд гал түлэх, түлээ нүүрс зөөх зэрэгт зарцуулдаг байсан цагаа өдөрт 40 хүртэлх минутаар хэмнэснээр хүүхдүүдтэйгээ тоглох, эсвэл өөртөө зарцуулах илүү чөлөөт цагтай болжээ.

Монгол гэрийн халаалт, дулаалгын багц төсөл хөдөө орон нутагт ногоон ажлын байр бий нэмэгдүүлж байна. 2021 онд дулаалгын багц бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж нийлүүлэхэд орон нутгийн 12 үйлдвэрийн 101 (59 нь эмэгтэй) хүн ажилтай болжээ. Мөн төслийн сургалтад нийт 2000 эмэгтэй хамрагдаж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг даван туулах, агаарын бохирдлыг бууруулах талаар мэдлэг, мэдээлэл, туршлагатай болсон. Агаарын бохирдлыг тогтвортой шийдвэрлэх, үүний зэрэгцээ Монголын эмэгтэйчүүдийн чөлөөт цагийг нэмэгдүүлж чадавхижуулах зорилгоор Монгол гэрийн халаалт, дулаалгын багц төслийг Монгол улс дахь НҮБ-ын Хүүхдийн сан хэрэгжүүлсэн.

Үр дүн 1.1.3 - Хөдөө орон нутгийн ядуу, эмзэг бүлгийн хүн амын амьжиргааг тэтгэдэг экосистемийн үйлчилгээг хамгаалах;

НҮБ-ын дэмжлэг, техникийн туслалцаатайгаар сүүлийн хоёр жилийн турш хэрэгжүүлсэн стратегийн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнд 2022 оны 1-р сарын 5-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх орон нутгийн арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг шинэчлэн боловсруулж баталсан. Энэхүү дагалдах хууль тогтоомж нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр төсвийн мөчлөгийн туршид үүсэх харилцааг зохицуулна.

Бэлчээрийн зохистой менежментийг удирдлага болгон ховордсон зүйлүүдийг хамгаалах, газрын доройтлыг сааруулахад чиглэсэн орон нутгийн төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн иргэд, эмзэг бүлгийнхэнд буцалтгүй тусламжийн 39 жижиг төслийг хэрэгжүүлэх боломж олгосон. Эдгээр жижиг төслүүдийг хэрэгжүүлсний үр дүнд орон нутгийн 300 гаруй иргэд шууд ашиг шимийг нь хүртэж, шинээр 30 гаруй ажлын байр бий болсон. 2021 онд хөдөөгийн зорилтот байршилд бэлчээрийн хяналтын 76 цэгийг шинээр байгуулснаар малчид, малчдын бүлгүүдэд зориулан зайнаас тандан судлах замаар маш өндөр нарийвчлалтайгаар боловсруулсан тоо мэдээллийг ашиглан бэлчээрийн дацын зураглалыг боловсруулсан нь малын байршил

тоо толгойг харгалзан улирлаар шилжин нүүдэллэх хөдөлгөөний хяналт зохицуулалтыг сайжруулсан.

Цаашлаад НҮБ-аас PlanetGOLD хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн төслийг хэрэгжүүлсэн. Эдгээр төслүүд нь алтны бичил уурхайн бодлого, эрх зүйн орчныг бий болгох, төрийн албан хаагчид болон бичил уурхайчдад зориулсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын

магадлан шинжилгээний удирдамж болон Албан ёсны худалдаа эрхэлдэг бичил уурхай эрхлэх эрсдлийг бууруулах дүрмийн талаарх сургалтуудыг зохион байгуулж, Сэлэнгэ аймагт байгуулах мөнгөн ус ашигладаггүй боловсруулах үйлдвэрийн зураг төслийг боловсруулж батлах зэргээр олборлогчоос цэвэршүүлэгч хүртэлх нэмүү өртгийн сүлжээ, бичил уурхайд мөнгөн ус ашиглахыг хязгаарлахад тодорхой хувь нэмэр оруулсан.



Бэлчээрийн доройтол малчдын хувьд хамгийн тулгамдсан асуудал болоод байна. © ХХААБ / Хангайхүү

Үр дүн 1.1.4 - Нутгийн иргэдийн гамшгийн эрсдлийг даван туулах чадварыг сайжруулах;

НҮБ нь олон нийтийн дунд өргөнөөр тархсан КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн эсрэг хэрэгжүүлж буй НҮБ-ын бүс нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлүүд, Монгол Улсын эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэлүүд зэрэгтэй уялдуулан КОВИД-19 цар тахалтай тэмцэх эрүүл мэндийн хариу арга хэмжээний стратеги, салбар дундын төлөвлөгөөг боловсруулах ажилд НҮБ дэмжлэг үзүүлсэн. Хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдал, Засгийн газраас баталсан цар тахалтай тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөөтэй уялдуулан Эрүүл мэндийн салбарын гамшгийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг холбогдох талуудтай хамтран шинэчлэн боловсруулж шаардагдах өртөг зардлыг тооцож батлуулсан.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Онцгой байдлын ерөнхий газар нь Олон улсын гамшгийн чартер: Сансрын мэдээлэл, томоохон гамшгийн платформын эрх бүхий хэрэглэгч болж бүртгүүлсэн учир томоохон гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хиймэл дагуулаас тухайн байршил дахь бодит цаг хугацааны өндөр нарийвчлал бүхий сансрын зураг хүлээн авах, ашиглах нөхцөл бүрдсэн. Түүнчлэн НҮБ-ын дэмжлэгтэйгээр Шадар сайдын ажлын алба болон хилийн мэргэжлийн байгууллагууд хамтран “КОВИД-19” цар тахлын халдварын дэгдэлтийн үед хилийн боомтын үйл ажиллагааг аюулгүй, тасралтгүй явуулах зорилгоор хилийн боомтуудад эрсдлийн үнэлгээ хийж, хилийн томоохон зургаан боомтыг үе шаттайгаар нээх бэлтгэл арга хэмжээ авч байсны үр дүнд Монгол Улс хилээ 2021 оны 6-р сараас дахин нээх боломж бүрдсэн билээ.



ОУХШБ-аас Ковид 19-ын улмаас гадаадад гацаад иргэдийг эргэн ирэхэд нь дэмжлэг үзүүлсэн. © ОУХШБ

НҮБ-ын дэмжлэгтэйгээр нийгмийн ажилтнуудад зориулсан дижитал кейс менежментийн системийг Монгол Улсад анх удаа нэвтрүүлж эхэлсэн нь орхигдох эрсдэл бүхий хүн амд, ялангуяа КОВИД-19 цар тахлын улмаас амь нас, амьжиргаанд нь аюул тулгараад байсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрч үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн. Энэхүү системийг нэвтрүүлснээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны удирдлагын хяналтад байгаа дижитал платформуор дамжуулан Монгол Улсын 728 нийгмийн ажилтан нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүстэй холбогдож, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх боломж бий болсон. Үүний үр дүнд тэргүүн шугамд ажиллаж буй ажилтнуудын үйлчилгээ улам бүр сайжирч, өнөөгийн байдлаар тэд эмзэг бүлгийн 40,000 гаруй хүмүүст хүрч ажилласан мэдээ байна.

НҮБ 2021 онд КОВИД-19 цар тахлын улмаас гадаадын 17 улсад гацсан нэн эмзэг бүлгийн 518 монгол иргэдийг аюулгүй, эмх журамтайгаар эх орондоо буцаж ирэхэд нь дэмжлэг үзүүлсэн. Эх орондоо эргэж ирсэн хүмүүсийн дийлэнх нь хөдөлмөрийн зах зээлд чиг баримжаа олж авах, ажил хайх, компьютерийн суурь мэдлэг эзэмших, ур чадвараа бэхжүүлэх, мөн тодорхой жижиг бизнес эрхлэх хүсэлтэй хүмүүст зориулсан сургалтуудад хамрагдах зэрэг нийгэмшүүлэх үйлчилгээнд хамрагдсан. Цаашид ийм төрлийн

сургалтуудыг залуучуудын дунд ихээхэн танил болсон Tomyo.mn болон Skillup.mn гэсэн нийтийн гар утасны цахим сургалтын хоёр платформ дээр зохион байгуулж байна. Үүний зэрэгцээ НҮБ нь Хүн амын хөгжлийн бодлого, Хөдөлмөрийн зах зээлийн загварчлал зэрэгт хүн амын өсөлт өөрчлөлтөд үзүүлж буй шилжилт хөдөлгөөний нөлөөллийг тусгах чиглэлээр ХНХЯ-тай хамтран ажилласны зэрэгцээ Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран хүн амын шилжилт хөдөлгөөний асуудлыг төрийн бодлого, Шилжилт хөдөлгөөний загварчлалд тусгах чиглэлээр мөн хамтран ажилласан. Энэ талаар Үр дүн 2.4-т өгүүлнэ.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр зорилтот төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлсний үр дүнд нийслэлийн хэмжээнд 221.9 га талбайд үерийн хамгаалалт хийж, 3419 айл өрхийн 1719 хашааг болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан. Үүнд үерийн хамгаалалтын 5 байгууламж барьсны зэрэгцээ хот орчмын 89 нөхөрлөлийн бүлгийн 1176 гишүүнийг чадавхижуулснаар тэд ойр орчимынхондоо нөлөөлж, үер усны болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх чадавхийг сайжруулах, улмаар засаглалын түвшинд тулгарч буй бэрхшээлийг арилгахад тус дөхөм болж байна. 2020-2021 оны өвөлжилт хүндэрч болзошгүй аюулаас эртнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд гамшигт нэрвэгдсэн 6 аймгийн эмзэг бүлгийн 1000 гаруй өрхийн 4500 гаруй малчдыг малын



НҮБ-Хабитат байгууллагаас Улаанбаатар хотын захын дүүргүүдэд үерийн хамгаалалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэв. © НҮБ-Хабитат

тэжээл, мал эмнэлгийн хэрэгслээр хангалаа.

Онцгой байдлын ерөнхий газартай нягт хамтран ажиллаж, 336 сумын захиргааны 1052 албан хаагчдад гар утсаар мэдээлэл цуглуулах Kobo Toolbox программыг ашиглах арга техникийг эзэмшүүллээ. Монгол Улсын мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоо, ялангуяа үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус хөрөнгө, хүнсний хэрэглээ, малчин өрхийн суурь үйлчилгээний хүртээмж зэргийг харгалзан Үр дүн 2.4-т дурдсан Дасан зохицох чадварын индексийг тооцож шинжлэх аргачлалыг Монголын нөхцөлд тохируулан өөрчилсөн. Ингэснээр малчин өрхийн дасан зохицох чадварын индекс 40.07 (дунджаар) гарч, хамгийн эмзэг байршил буюу өндөр оноотой аймгуудыг тодорхойлох боломжийг бүрдүүлсэн.

Цаашлаад, НҮБ нь хүүхэд, айл өрхүүдийн байгалийн гамшгийн эрсдлийг даван туулах чадавхийг нэмэгдүүлэхийн тулд хүүхэд төвтэй гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллаж, орон нутгийн засаг захиргаадыг хүүхдэд ээлтэй Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ) болон Өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөгөө (ӨБХТ) боловсруулахад дэмжлэг үзүүлэв. ГЭБ болон ӨБХТ-тэй холбоотой өнөөгийн хэрэгжүүлж байгаа 56 бодлого, журамд хүүхдийн асуудлыг хэрхэн тусгасан талаар хийсэн үнэлгээнд суурилж үндэсний болон орон нутгийн түвшний төр засгийн байгууллагуудад бодлогын зөвлөмж хүргүүлсний үр дүнд ГЭБ болон ӨБХТ-тэй холбоотой бодлогын дөрвөн үндсэн баримт бичгийг өөрчлөн шинэчилж чадсан.



. © НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 2:

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ, ЧАНАРТАЙ, ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БИЙ БОЛГОХ



9
НҮБ-ын системийн
байгууллага



61.5
сая ам.доллар



109
төсөл,
хөтөлбөр



34
түнш
байгууллагууд

9



сургууль

6



цэцэрлэгийн

Ариун цэврийн
байгууламжийг
сайжруулсны үр шимийг



6900

гаруй хүүхэд

Халдвараас сэргийлэх
эрүүл ахуй, ариутгалын
багц бүтээгдэхүүн



948 сургууль



540 дотуур байр



672 цэцэрлэг



876,600 хүүхэд

100,000

амьд төрөлтөд ногдох
эхийн эндэгдэл



94.9



Эхийн эндэгдлийн

68 бүртгэгдсэн
тохиолдлын

47



КОВИД-19-ийн
улмаас



1,000

амьд төрөлтөд ногдох тав
хүртэлх насны хүүхдийн
эндэгдэл

14



КОВИД-19 цар тахлын үед
зайн сургалтад хамрагдах
боломжгүй байсан 2-17
насны хүүхэд:

33%

2020 оны эцэс



42%

2021 оны 6-р сард

98%

2021 оны 9-р сард
буюу сургуулиудын
үйл ажиллагаа эхлэх үед

ЕБС-ын үйл ажиллагааг
аюулгүй нээх сургалт



5,000

багш ажилтан



Эмзэг бүлгийн



11,000

гаруй шилжин суурьшигчдад
зориулсан дэмжлэг



19,708

хүүхдийг үзлэг
шинжилгээнд хамруулж,
хоол тэжээлийн цочмог
дуталд орсон



192

хүүхдийг эрчимт
эмчилгээнд хамруулсан.

46,000

гаруй хүүхэд, эхчүүдэд



хоол тэжээлийн талаар
зөвлөгөө


Үр дүнгийн зорилт 2-ын хэрэгжилтэд хувь
нэмэр оруулсан НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд:



Үр дүнгийн зорилт: 2021 он гэхэд ядуу, эмзэг бүлгийн хүн ам нийгмийн илүү сайн хамгаалалтаас ашиг тус хүртэж, чанартай, тэгш, хүртээмжтэй нийгмийн суурь үйлчилгээгээр, ялангуяа ундны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээгээр илүүтэй хангагдана.

НҮБ нь эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, ундны ус, ариун цэвэр, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал зэрэг чанартай, эрх тэгш нийгмийн үйлчилгээг хүн амд тууштай хүргэхэд чиглэсэн хамтын ажиллагаагаа КОВИД-19 цар тахлын хямралаас сургамж аван үргэлжлүүлж байна. Энэ хүрээнд НҮБ-ын системийн нийт есөн байгууллага хамтран 61.5 сая ам.долларын санхүүжилтийг татан төвлөрүүлсэн бөгөөд хэрэгжүүлэгч нийт 34 түнш байгууллагуудтайгаа хамтран тус улсын нийт аймаг, нийслэл Улаанбаатар хотод 109 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

НҮБ-ын төсөл хөтөлбөрүүд Үр дүнгийн зорилт 2-ын хүрээнд Тогтвортой хөгжлийн дараах зорилгуудын хэрэгжилтэд хувь нэмэр оруулж байна.



Баянхонгор аймгийн зарим сургуулийн ариун цэврийн байгууламжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэв. © НҮБ-ын Хүүхдийн сан

Үр дүн 2.1 Технологийн шийдэл, ус, ариун цэврийн байгууламжийн тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх замаар илүү таатай орчин бүрдсэн, мэдээлэл судалгаатай, нийгмийн ухамсараар дэмжигдсэн Ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сонгогдсон хотын захын хороолол болон сумдад сайжруулах;

Хэдийгээр ундны усны үндсэн үйлчилгээний хүртээмжид (85 хувь) дорвитой ахиц дэвшил ажиглагдаагүй ч Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа+ 2020-2021 (ОУБТС+)-нд оролцогчдын 74 хувь нь гар угаах, ариутгах дадлыг эзэмшсэн хэмээн мэдээлсэн байна.

НҮБ-аас дэмжлэгтэйгээр эрсдэлийн удирдлагад суурилсан Усны аюулгүй байдлын төлөвлөгөө болонцэцэрлэг, сургууль, дотуур байрны ундны ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах үндэсний хэм хэмжээ, шаардлагуудыг тогтоож хэрэгжүүлснээр орон нутгийн засаг захиргааны удирдлагууд ариун цэврийн байгууламжийг сайжруулах зорилгоо уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийг давах чадварыг бий болгох арга хэмжээнийхээ бүрэлдэхүүн хэсэгт оруулах боломжтой болох юм. Өнөөгийн байдлаар 100 орчим сум Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан баталж улмаар чадавхи бэхжүүлэх, хөндлөнгийн аудит хийх замаар хяналтын механизмыг тогтоосон. 6900 гаруй хүүхэд суралцдаг нийт 9 сургууль (дотуур байрыг оруулаад), 6 цэцэрлэг уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийг даах чадвартай. Ундны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжид (жишээ нь, ус, эрчим хүчний хэмнэлттэй технологи ашигласан дотроо бие засах газар, шүршүүрийн өрөө, гар угаагууртай байгууламжууд) холбогдоод байна.

НҮБ-ын санаачлан байгуулсан олон нийтэд зориулсан ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн загваруудыг төр засгийн байгууллагууд талархан хүлээн авч түгээн дэлгэрүүлж байгаа нь ажиглагдаж байна. Үүний нэг жишээ бол Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-ны улсын хэмжээнд дотроо ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжтай сургууль

барих/засварлах 2021 оны санхүүжилтийг нэмэгдүүлсэн явдал юм. Цаашид эдгээр байгууламжийг үр дүнтэй ажиллуулах, засвар үйлчилгээг тогтмол хийхэд шаардагдах зардлыг тооцож, улс, орон нутгийн болон бусад эх үүсвэрийг хослуулсан тогтвортой санхүүжилтийн механизмыг хөгжүүлэхэд нөлөөлөл сурталчилгааг чиглүүлэх шаардлагатай.

КОВИД-19 цартахлын уршиг нөлөө үргэлжилсээр байгаа нь Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрүүдэд дарамт учруулаад зогсохгүй ариун цэвэр эрүүл ахуйн сурталчилгаанд нэмэлт хүчин чармайлт гаргах шаардлага тавигдсан. Халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тавих чадавхийг нэмэгдүүлсний зэрэгцээ хоёр, гуравдугаар шатлалын эмнэлгүүдийн сургалт болоод өдөр тутмын хяналтад зориулж гарын эрүүл ахуйн сахилтыг хянах төхөөрөмжийг ханган нийлүүлж чадавхийг нь бэхжүүлсэн.

Боловсролын байгууллагуудын тусгаарлах өрөөнд хэрэглэх нэн шаардлагатай гар ариутгагч, эрүүл ахуйн багц зэрэг эрүүл ахуй, урьдчилан сэргийлэх чухал хэрэглэгдэхүүнийг эн тэргүүнд 948 сургууль, 540 дотуур байр, 672 цэцэрлэгт нийлүүлж, 876,600 хүүхдэд хүрч үйлчилсэн. Орон нутгийн худалдан авалт, нийлүүлэлтийн үйл явцыг БШУЯ, Монголын Улаан Загалмай Нийгэмлэг хамтран зохион байгуулж ажилласан.




Нярай үрдээ ангир уургаа амлуулахад нь тусалж буй сувилагч. © ДЭМБ

Үр дүн 2.2 Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж хот суурин, хотын захын хороолол, хөдөө орон нутгийн ядуу, эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулах; эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээнд хүн бүр тэгш хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх; нотолгоонд суурилж бодлого, шийдвэр гаргахад үндэсний байгууллагууд хамтран ажиллахыг дэмжих;

НҮБ нь COVID-19-ийн эсрэг вакцин худалдан авах, 2021 оны эцэс гэхэд тус улсын нийт хүн амын 43 хувийг COVID-19-ийн эсрэг гурван тун дархлаажуулалтад хамруулах кампанит ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн. Түүнчлэн төв болон орон нутгийн түвшинд хүйтэн хэлхээний хүчин чадлыг өргөжүүлэх, вакцины шинэ дэлгүүр байгуулах, мөн вакцин хадгалдаг байсан хуучин хөргөгч/хөлдөөгчийг солих зэрэг ажлуудад НҮБ-ын зүгээс дэмжлэг үзүүлсэн. Өргөн хүрээг хамарсан дархлаажуулалтын аян, нөлөөлөл сурталчилгааны кампанит ажлууд эхлэхийн өмнө сүргийн дархлааг бий болгох стратегийг чадавхи бэхжүүлэх арга хэмжээнүүдтэй хослуулсан нь нэг талаас түгшүүртэй байсан хэдий ч эрүүл мэндийн тогтвортой үр дүнд хүрч чадсан.

1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 14 байна. Харамсалтай нь 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 94.9 болж өссөнөөр Монгол Улсын эхийн эндэгдлийг бууруулсан амжилтыг арав гаруй жилээр ухраасан (эхийн эндэгдлийн бүртгэгдсэн 68 тохиолдлын 47 нь COVID-19-ийн шалтгаанаар энджээ). Жирэмсэн үедээ б-аас доошгүй удаа жирэмсний хяналтын үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн хувийн жин буурсан нь COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс жирэмсэн эмэгтэйчүүдийг олон хүн цугларсан эмнэлгүүдэд ирж үзлэг, шинжилгээ хийлгэхгүйгээр, аль болох утсаар дуудлага өгч зөвлөгөө авч байхыг зөвлөж байсан, гэсэн атлаа утсаар дуудлага өгч зөвлөгөө авсан тохиолдлуудыг үзлэгт хамрагдсанд тоцоогүйтэй холбоотой байж болох юм. Сүүлийн жилүүдэд өсвөр насныхны төрөлт буурч байгаа нь доорх зургаас ажиглагдаж байна.



Зураг 2.2.1: 15-19 насны 1000 эмэгтэйд ногдох өсвөр насны охидын төрөлт, ЭМЯ

Цар тахлаас сэргийлж хөл хорио, хязгаарлалт тогтоосон үед COVID-19-тэй холбоотой болон холбоогүй бүхий л нэн чухал үйлчилгээг телемедицин, хөдөлгөөнт үйлчилгээ, технологийг ашиглан эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлж байв. Эдгээр шинэлэг арга технологийг COVID-19 цар тахлын үед болон түүнээс хойш ч эрүүл мэндийн бусад тусламж үйлчилгээ, хөтөлбөрүүдэд хэрэгжүүлэх боломжтой юм.

Н-Info 3.0 програм болон хүүхдийн эндэгдлийн хяналтын системийг шинэчлэх зэрэг эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн удирдлагын системийг бэхжүүлэх замаар эрүүл мэндийн үйлчилгээг хүн амд үр дүнтэй хүргэж, системийн гүйцэтгэл, үр дүнд цаг тухайд нь хяналт тавих нөхцөл боломж бүрдсэн. Цахим бүртгэлийн системд нэмэлт олон функц оруулснаар үйлчилгээ авагчид (хүмүүс) болон үйлчилгээ үзүүлэгчид (эмнэлгүүд) шаардагдах “COVID-19-ийн эмчилгээний багц”-ыг авах нөхцөл бүрдэж ийм үйлчилгээний төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх боломжтой болсон. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх түвшинд гүйцэтгэлд суурилсан үйлчилгээг дэмжих эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд Сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны нэг хүнд ногдох төсөв 2021 онтой харьцуулахад хоёр дахин нэмэгдсэн.

Эрүүл мэндийн яам (ЭМЯ) болон Монгол Улсын Засгийн газар нь НҮБ-ын дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн салбарын бүх түвшний тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид үнэлгээ хийж, шинэчилж, бэхжүүлсний үр дүнд Монгол Улсын хүн амд эрүүл мэндийн тогтолцооны бүх түвшинд хамгийн сүүлийн үеийн, нотлогдсон, мэдээлэлд суурилсан зөвлөгөөг хүргэх боломжтой болсон. Энэ хүрээнд Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө (2022-2024)³ -г боловсруулан баталсан бөгөөд цар тахлын дэгдэлтийн үед эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт бус өвчин Монг-Пен буюу Зүрх судасны өвчний эрсдэлд суурилсан менежмент болон халдварт өвчинтэй тэмцэх нэн шаардлагатай багц үйлчилгээний төвүүдийг бий болгосон.

³ Эрүүл мэндийн яам. (2021 оны 12 дугаар сарын 9). “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай. Үзэх <https://moh.gov.mn/uploads/files/e25ebef7cbe51d7481c025197533dfbdbc231682.pdf>

Үр дүн 2.3 Илүү чанартай суурь боловсролыг дэмжиж, хүүхдийг бага наснаас нь хөгжүүлэх, улмаар насан турш боловсрол эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хотын захын хорооллын сонгогдсон хэсгүүд, зарим сумдад хэрэгжүүлэх;

НҮБ-аас хүн амын боловсролыг дээшлүүлэхэд үзүүлж буй дэмжлэг нь бага насны хүүхдийн боловсролоос эхлээд дээд боловсрол хүртэлх боловсролын системийн бүх түвшинд хэрэгжиж буй боловсролын салбарын мастер төлөвлөгөө, бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулж үндэсний хэмжээнд Тогтвортой хөгжлийн дөрөв дэх зорилгыг (ТХЗ 4) нутагшуулан хэрэгжүүлэх, чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн. Түүнчлэн сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсрол, бага, дунд боловсролын цахим сургалтын платформыг хөгжүүлж нэвтрүүлэхэд НҮБ дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн НҮБ-ын зүгээс эрүүл мэндийн болоод бэлгийн боловсрол олгох интерактив хичээлүүдийг монгол, казах, тува хэл дээр бэлтгэж, хүүхэд, залууст цахимаар суралцах боломжийг нээж, сонсголын бэрхшээлтэй хэрэглэгчдэд хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэхийг дэмжиж ажилласан. НҮБ-ын дэмжлэгтэйгээр БШУЯ манлайлан Боловсролын системийн Мэдээлэл харилцаа холбооны технологийн бодлогод үнэлгээ хийж Боловсролын салбарын шинэ Мастер төлөвлөгөөнд мэдээлэл харилцаа холбооны технологийн асуудлыг анх удаа цогц хэлбэрээр тусган батлуулж хэрэгжүүлэхээр зорьж байна. Гэсэн хэдий ч зайн сургалтад хамрагдах боломжгүй байсан 2-17 насны хүүхдүүдийн хувийн жин 2020 оны эцэст 33 хувийг бүрдүүлж байсны зэрэгцээ 2021 оны 6-р сард 42 хувь болон буурсан бөгөөд сургуулиудын үйл ажиллагаа эхлэх үед бага сургуульд элсэгчид 98 хувь болж нэмэгдсэн.

НҮБ-аас мэдээлэл сурталчилгаа, техникийн тусламжаа үргэлжлүүлж ирсэний үр дүнд Монгол Улсын Засгийн газар бэлгийн цогц боловсрол) болон амьдрах ухааны боловсрол, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний уялдаа холбоог сайжруулснаар бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих зэрэг хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан. Ингэхдээ эрүүл мэндийн боловсролын агуулгыг бие даасан

хичээл хэлбэрээр боловсруулж, сургалтын хөтөлбөр, хичээл заах гарын авлагад бэлгийн цогц боловсролыг гол сэдвүүдийн нэг болгон оруулсан. Түүнчлэн НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар нь 14 хүртэлх насны хүүхдүүдийн насных нь онцлогт тохирсон нийт 50 гаруй баримтат видео бичлэгийг монгол хэлнээ хөрвүүлж сургалтад ашиглаж эхэлсэн. Хүүхдийн насны онцлогт тохирсон видео бичлэгийг Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй цахим сургалтын платформын цахим эх сурвалжаас <https://medle.mn> үзэх боломжтой.

НҮБ нь бусад түнш байгууллагуудтайгаа хамтран цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого, хүүхдийн хөгжил, хүүхдийг сургуульд бэлтгэж байгаа байдалд хяналт шинжилгээ хийх удирдамжийг боловсруулж үндэсний хэмжээнд нэвтрүүлэх, түүнчлэн салбар хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор зорилтот бүс нутгийн эцэг эхчүүдэд зориулсан Хүүхдийг асран хүмүүжүүлэх дадлыг бий болгох чиглэлээр БШУЯ-нд дэмжлэг үзүүлж ажиллав. Энэ хүрээнд нийт 2280 багш, 3920 эцэг эхийг чадавхижуулж, цэцэрлэгийн орчныг сайжруулсан бөгөөд 24 цагийн цэцэрлэгт хамрагдаж буй нийт 4950 хүүхэд бага насны хүүхдийн хөгжил, боловсролын илүү чанартай үйлчилгээ хүртсэн.

КОВИД-19 цар тахлын үеийн нөхцөл байдал нь хүүхэд, өсвөр насныхны бие бялдар, сэтгэл зүйн төлөв байдалд онцгой анхаарал хандуулах шаардлагатайг харуулсан. Үүнтэй холбогдуулан өсвөр насны хүүхдийн эмч нарт зориулсан төгсөлтийн дараах сургалтын анхны хөтөлбөр болон өсвөр насны хүүхдийн эмч нар, сургуулийн эмч нарт зориулсан ажлын байран дээрх цахим сургалтын богино хэмжээний хөтөлбөрүүд, түүнчлэн өсвөр үеийнхэнд Сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай бодлогын баримт бичгийг боловсруулах замаар өсвөр үеийнхний эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас дэмжлэг үзүүлэв. Сайн дурынхны оролцоотойгоор сэтгэцийн эрүүл мэнд болон агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг амжилттай зохион байгуулж 90,000 гаруй хүнийг хамруулсан.

Мэдээлэл сурталчилгаа, салбар хоорондын

идэвхтэй хамтын ажиллагааны үр дүнд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг буцааж сэргээхэд НҮБ-ын зүгээс иж бүрэн дэмжлэг үзүүлж чадсан. Тухайлбал, сургууль, цэцэрлэгийн 5000 гаруй ажилтнуудад зориулан сургуулийн үйл ажиллагааг аюулгүй нээх заавар, журам

боловсруулж, холбогдох сургалтуудыг зохион байгуулсан. Боловсролын үйлчилгээг тасралтгүй явуулж, сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгах зорилгоор сургуулийн үйл ажиллагаа зогссон үеэр 1, 2-р ангийн 30,000 хүүхдийг хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангасан.



Цар тахлын улмаас алсын зайн сургалтад шилжсэн үед хөдөөгийн сурагчдад хичээлийн хоцрогдлыг арилгахад туслах аудио хичээлээ сонсож буй малчдын хүүхдүүд.

Үр дүн 2.4 Нийт хүн амыг, ялангуяа, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг түлхүү хамруулсан үр ашигтай, үр нөлөө бүхий нийгмийн хамгааллын тогтолцоог нэвтрүүлэх,

Малчдын амьдрах арга ухааны ур чадварыг сайжруулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаарх мэдлэгийг шинэ түвшинд гаргах, нийгмийн даатгалын үр өгөөжийн талаарх тэдний ойлголтыг нэмэгдүүлэх үндсэн зорилго бүхий малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлэх хөтөлбөрийг улсын хэмжээнд анх удаа боловсруулан хэрэгжүүлсэн.⁴ НҮБ-аас дэмжлэг үзүүлсний үр дүнд Завхан аймгийн зорилтот 5 сумын малчдын нийгмийн болоод эрүүл мэндийн даатгалд хамрагдалт 10 хувиар нэмэгдсэн нь улсын хэмжээнд мөн хугацаанд нийгмийн даатгалд хамрагдалт 5 хувиар⁵ нэмэгдэхэд нөлөөлсөн. КОВИД-19 цар тахлаас үүдсэн хямралын үед засгийн газар болон олон нийтэд нийгмийн хамгааллын хөтөлбөр ямар чухал болохыг мэдрүүлсэн. Монгол Улсын Засгийн газар 2020 оны 4-р сараас 2021 оныг дуустал нийгмийн даатгалын албан журмын

болон сайн дурын шимтгэлийг хэсэгчлэн хөнгөлж, 2020-2021 онд “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хуулийг хэрэгжүүлсэн.⁶

Монгол Улсын Засгийн газар нь НҮБ-ын дэмжлэгтэйгээр Даван туулах чадварын индексийн тооцоо, шинжилгээний аргачлалыг ашиглан цочролд мэдрэмжтэй нийгмийн хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги, гамшгийн эрсдэлийн үнэлгээ (ган, зуд) зэрэг үндэсний хэмжээний холбогдох бодлогын шинэчлэлд Бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой байдлын тухай ойлголтыг тусгасан. Ийнхүү Даван туулах чадварын индексийн тооцоо, шинжилгээ (RIMA-II)-ний аргачлалыг ашигласнаар засгийн газар цочролын эсрэг хариу арга хэмжээ авахад тусламж шаардлагатай зорилтот хүн амыг тодорхойлох боломжтой болж байгаа юм.

Нийгмийн хамгааллын тогтолцооны үр нөлөө (хамрах хүрээ, хүртээмж), үр ашиг, тогтвортой

⁴ Монгол Улсын Малчдын хөтөлбөр, ТХЗ-ын Хамтарсан сан. Үзэх <https://jointsdgfund.org/where-we-work/mongolia>
⁵ Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар. Үзэх <https://www.ndaatgal.mn/v1/!st>.
⁶ “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хууль (2020 оны 1-р сард). Энэ хуулиар 1995-2020 онд төлөөгүй байсан нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх нэг удаагийн боломж олгосон.

байдлыг хангах, тэр дундаа нэн эмзэг бүлгийнхний (малчид болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртсөн хүмүүс) хамрагдалтыг өргөжүүлэх зорилгоор “Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын зан төлвийн судалгаа” хийх, “Нийгмийн хамгааллын өнөөгийн тогтолцоонд оношилгоо хийж, санхүүжилтийн стратег-ийг боловсруулах замаар нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн хамгааллын санхүүжилтийн стратегийг боловсронгуй болгоход шаардагдах тоо мэдээллийн санг бүрдүүлэх зэрэг чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн.⁷

Цаашлаад, үндэсний болон орон нутгийн түвшинд өргөн хүрээний мэдээлэл сурталчилгааны ажил хийсний үр дүнд дотоодын шилжих хөдөлгөөнд оролцогчдыг системийн бүтцийн хувьд орхигдох эрсдэлтэй эмзэг бүлэг хэмээн хүлээн зөвшөөрч, шилжилт хөдөлгөөний асуудал, түүнтэй холбогдох тоо мэдээллийг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах, улмаар шилжих хөдөлгөөний урсгалыг хотоос хөдөө рүү чиглүүлж

өөрчлөхүйц шилжилт хөдөлгөөний бодлого боловсруулах алхам тавигдсан. Түүнчлэн шилжин суурьшигчдын асуудлыг шийдвэрлэх, улмаар нийслэл Улаанбаатар хотод шилжин ирж буй хүмүүстэй хамтран асуудлыг нь үр дүнтэй зохицуулах талаарх төрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх санал санаачлагууд гарч байна. Эмзэг бүлгийн 11,000 гаруй шилжин суурьшигчдад сэтгэл зүйн зөвлөгөө болоод хөдөлмөр эрхлэлт, бичиг баримт бүрдүүлэлтийн үйлчилгээ зэрэг нийгмийн дэвшилтэт үйлчилгээг шууд хүргэх ажлыг зохион байгуулсан. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Улаанбаатар хот болон 11 аймаг дахь шилжих хөдөлгөөний асуудлаар үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн ТББ-уудын MigNet сүлжээгээр дамжуулан 200,000 гаруй өнөөгийн болоод ирээдүйн шилжин суурьшигчдад зохих мэдээлэл хүргэн ажиллаа. Түүнчлэн НҮБ-аас Улсын бүртгэлийн ерөнхий газар тай хамтран нэн эмзэг бүлгийн 1000 гаруй шилжин суурьшигчид иргэний үнэмлэх олгох ажлыг зохион байгуулж оршин суугаа хаягийн бүртгэлийг нь төрийн цахим үйлчилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлэв.



Орон нутгаас шилжин ирэгсэд голчлон УБ-ын гэр хороололд суурьшиж байна. ОУХШБ / У.Одбаяр

⁷Монгол Улс. НҮБ-ын Хамтарсан хөтөлбөр (2021 оны 10 дугаар сарын 19) “Нийгмийн хамгааллын тогтолцооны оношилгоо, санхүүжилтийн стратеги. Үзэх https://www.ilo.org/beijing/information-resources/public-information/press-releases/WCMS_824673/lang-en/index.htm.

Оршин суугаа хаягийн бүртгэлгүй байх явдал нь нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг үр дүн, үр нөлөөтэй явуулахад тулгардаг гол бэрхшээлүүдийн нэг бөгөөд эмзэг бүлгийн хүмүүс, тэр дундаа шилжин ирэгсэд ихэвчлэн тодорхой оршин суугаа газрын хаяггүй, бүртгэлгүй байдаг. Хаягийн бүртгэлийг сайжруулж төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Үлдэх үү, явах уу? Судаль” гэсэн мэдээллийн кампанит ажлыг зохион байгуулж, 2 сая гаруй хүнийг хамруулсан. Мэдээллийн энэхүү кампанит ажил нь хүмүүс тодорхой мэдээлэлд суурилж шилжин суурьших шийдвэр гаргах, түүнчлэн шилжих хөдөлгөөний урсгалыг хотоос хөдөө рүү чиглүүлж өөрчлөхөд тодорхой хувь нэмэр оруулсан.

Үр дүн 2.5 - Хүнс болон хоол тэжээлийн аюулгүй байдлыг бэхжүүлэх (эрүүл хүнс/тэжээлийн орчинг бүрдүүлэх, хоол тэжээлийн дутлын эрсдлийг эрс бууруулах, хүнс, хоол тэжээлийн тандан судалгаа, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх).

НҮБ-ын Ерөнхий Ассамблей-гаас 2021 оныг “Жимс жимсгэнэ, хүнсний ногоо”-ны жил болгон зарласан билээ. Энэхүү тэмдэглэлт жилийг НҮБ нь холбогдох 15 байгууллагын хамт жилийн турш дэмжин ажиллаж жимс, хүнсний ногоо нь хүний хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндэд нэн чухал төдийгүй ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх тухай ойлголтыг сайжруулах онцгой боломж бүрдсэн. Хөгжлийн түншүүд, үйлдвэрлэгчид, судлаачид, санхүүгийн байгууллагууд зэрэг өргөн салбаруудыг хамруулж тодорхой стратегитай, нэгдсэн, хүртээмжтэй хөдөө аж ахуй-хүнсний тогтвортой тогтолцоог бүрдүүлэхэд нь Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх зорилгоор “Монгол Улсын Хүнсний тогтвортой тогтолцоо” сэдэвт үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг зохион байгуулахад НҮБ туслалцаа үзүүлсэн.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр улсын хэмжээнд тав хүртэлх насны 358,494 хүүхдийг А аминдэмийн бэлдмэлээр хангаж, 19708 хүүхдийг үзлэг шинжилгээнд хамруулсан бөгөөд 192 хүүхэд хоол тэжээлийн цочмог дутагдалтай байсныг илрүүлж, амь насыг нь аврах эмчилгээнд оруулсан. Түүнчлэн 46,000 гаруй хүүхэд, эхчүүдэд хоол тэжээлийн талаар зөвлөгөө өгч ажиллаа. КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн үеэр хүүхэд, өсвөр үеийнхний дунд явуулсан судалгаагаар тав хүртэлх насны хүүхдүүдийн

48 хувь, 10-19 насны өсвөр үеийнхний 42 хувьд жингийн өөрчлөлт ажиглагдсан бөгөөд тэдний 86 хувь нь жин нэмэгдсэн хэмээн мэдээлсэн. Мөн Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаанд оролцогчдын 22 хувь нь хүнсний аюулгүй байдлын асуудалтай тулгардаг хэмээн мэдээлсэн бөгөөд тэдний дийлэнх нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Тус улсын хүүхдүүдийн дунд жингийн илүүдэл, таргалалт ихээхэн түгээмэл байгааг нийт аймгуудыг хамруулж хийсэн судалгааны үр дүн харуулсан нь Засгийн газрын зүгээс Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нотолгоо (одоогоор хэлэлцэж байгаа) болсон. Монгол Улсад жингийн илүүдэлтэй хүүхдүүдийн хувийн жин сүүлийн 10 жилд маш хурдацтай нэмэгдэж, тав хүртэлх насны хүүхдүүдийн 10.5 хувь, 5-19 насны хүүхдүүдийн 17.6 хувийг бүрдүүлж байна. Цаашлаад сургуулийн цайны газар, дотуур байр, цэцэрлэгийн гал тогоонд үйлдвэрлэж байгаа хоолны жорыг стандартчилах, сургуулийн хоол тэжээлийн орчныг сайжруулах чиглэлээр НҮБ-ын зүгээс тодорхой алхамуудыг хийж байна.

НҮБ-аас цаашлаад лабораторийн шинжилгээний аргын стандартыг тогтоож баяжуулсан гурил, иоджуулсан давс, нэмэлт хольц зэрэг бүтээгдэхүүнүүдийг хүнсний лабораториудаар баталгаажуулах зэрэг үндэсний хэмжээнд мэргэжлийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэв. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Цахим-хөдөө аж ахуйн үндэсний стратегийг боловсруулан баталснаар тус улсын хөдөө аж ахуйн салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглаж бүтээмжийг дээшлүүлэх, тариаланчдын орлогыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүллээ.

Уур амьсгалын өөрчлөлтөөс Монгол Улсын хүн амын хүнс, хоол тэжээлийн аюулгүй байдалд үзүүлж буй нөлөөллийг судлах зорилгоор НҮБ нь Олон улсын хүнсний бодлогын судалгааны хүрээлэнтэй хамтран анхны үнэлгээг эхлүүлсэн. Энэхүү судалгааны үр дүнд суурилж уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд тэсвэртэй хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхэд НҮБ үйл ажиллагаагаа чиглүүлэх болно.



Ааруул, цагаан идээгээ базааж буй малчин эмэгтэй. © ХХААБ / Батзаяа

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 3:

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЖ, ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ



8

НҮБ-ын системийн
төрөлжсөн
байгууллага



5.2

сая ам. доллар
2021 онд



24

сая ам.доллар
2017 оноос



32

хэрэгжүүлэгч
байгууллага



Хүний эрхийн төлөв байдлын
ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг
(UPR)-ийн зөвлөмжүүдийн

89%

бүрэн хэрэгжүүлсэн.



2017-2020 онд ЖСХ-тэй
тэмцэхэд зориулсан улсын
болон орон нутгийн төсөв
6.2 тэрбум төгрөг
болж нэмэгдсэн.

2017-2021 онд ЖСХ-д
өртсөн бүх насны нийт



15,641

хохилогчдод нэн
шаардлагатай үйлчилгээ



Цар тахлын үеийн
хамгааллын үйлчилгээний
үйл ажиллагааны стандарт
боловсруулсан



Улс төрд оролцох
эрмэлзэлтэй эмэгтэйчүүдийг
дэмжих Эмэгтэйчүүдийн
манлайллын сүлжээ
хөтөлбөрт

УБ
хотын **301** хөдөө орон
нутгийн **268**
эмэгтэй хамрагдав.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй
тэмцэх аяны үр дүнд:

3

цагдаад
хандаж
тусламж
эрэлхийлсэн.



Сураггүй
алга
болсон

12
хүүхэд
олдсон.

“КОВИД-19”-ийн хуулийн
үйлчлэлийн хүрээнд
томилогдсон төрийн албаны



1,100 гаруй

томилгоог хүчингүй
болгосон тогтоолыг Төрийн
албаны зөвлөл баталсан.



2017 оноос хойш
залуучуудын орон нутгийн

331

салбар зөвлөл,



36

Залуучуудын хөгжлийн төв



152,633

залуучуудад
хүрч үйлчиллээ.



Цар тахлын үед

1,114

сайн дурын ажилтан хүүхэд
хамгааллын аянд нэгдэж
Эрүүл ахуй, ариутгал
халдваргүйжүүлэлтийн
чиглэлээр



1,277

сайн дурын ажилтан мэдээлэл
түгээхэд оролцсон.

Үр дүнгийн зорилт 3-ын хэрэгжилтэд хувь
нэмэр оруулсан НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд:



Үр дүнгийн зорилт: 2021 он гэхэд засаглалын байгууллагууд нь залуучуудын үр дүнтэй оролцоог дэмжиж, ядуу, эмзэг бүлгийнхний болон хүн бүрийн хүний эрхийг дээдэлж, ард иргэдийнхээ өмнө илүү нээлттэй байж, хүлээх хариуцлагаа дээшлүүлсэн байна

НҮБ-ын төсөл хөтөлбөрүүд Үр дүнгийн зорилт 3-ын хүрээнд Тогтвортой хөгжлийн дараах зорилгуудын хэрэгжилтэд хувь нэмэр оруулж байна.



Үр дүн 3.1 Хүний эрхийг хамгаалах, ялангуяа, ядуу, эмзэг бүлгийнхний эрхийг хамгаалахын тулд хууль эрх зүйн хамгааллын механизмыг сайжруулж (олон улсын стандартад нийцүүлэн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах), хяналтын тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэх.

2021 оны байдлаар Монгол Улс нь Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)-ийн зөвлөмжүүдийн 89 хувийг нь бүрэн (56/150 зөвлөмж буюу 37%) буюу хэсэгчлэн (77/150 зөвлөмж буюу 51%) хэрэгжүүлсэн бөгөөд 2 зөвлөмжид нь тайлбар хийжээ. ЭАБХУК)-ийн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг бэлтгэж байгаа бөгөөд 2022 онд болох ЭАБХУК-ийн чуулганд танилцуулах болно.

Хууль эрхзүйн шинэчлэлд оруулсан хувь нэмэр	Мэдээлэл, ухуулга, сурталчилгаа	Хуулийн шинэчлэлд үзүүлэх техникийн болон санхүүгийн дэмжлэг	Хуулийн хэрэгжилттэй холбоотой техникийн болон санхүүгийн дэмжлэг	Хяналт, үнэлгээ
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	✓	✓	✓	✓
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	✓	✓	✓	✓
Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль	✓			
Хүүхэд хамгааллын тухай хууль	✓	✓	✓	✓
Эрүүгийн хууль (Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэсэг)	✓	✓	✓	✓
Зөрчлийн тухай хууль (Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэсэг)	✓	✓	✓	✓
Хөдөлмөрийн тухай хууль	✓	✓	✓	
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	✓	✓		

бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг томоохон хуулиудаас гадна салбаруудын хэмжээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журам, заавар, дүрмийг боловсруулах, холбогдох судалгаа, үнэлгээ хийх чиглэлээр техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлээ. Эдгээр хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхийн зэрэгцээ, НҮБ болон иргэний нийгмийн байгууллагууд мэдээлэл сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд зохион байгуулсны үр дүнд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагаа сайжирсан нь 2017-2020 онуудад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээнд зориулсан улс, орон нутгийн төсөв 6.2 тэрбум төгрөг болж нэмэгдсэнээр илэрч байна. Түүнчлэн НҮБ-аас 2021 онд Олон салбарын төлөөллийн багууд-ын стандарт үйл ажиллагаа, санхүүжилтийн журамд өөрчлөлт оруулахад дэмжлэг үзүүлээ. Ингэснээр улсын хэмжээний 748 ОСТБ-ынн төсвийн хуваарилалтыг баталгаажуулж, олон салбарыг хамарсан үйлчилгээний чанарыг сайжруулах, улмаар Нэг цэгийн үйлчилгээний төвүүд (НЦҮТ) болон хамгаалах байруудаар дамжуулан жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйчилгээ үзүүлэх хүртээмжийг нэмэгдүүлж байгаа юм.

НҮБ болон бусад оролцогч талуудын тууштай манлайлал, нөлөөллийн үр дүнд НЦҮТ болон хамгаалах байрууд нь КОВИД-19 цар тахлын дэгдэлт болон хөл хорионы үед нэн шаардлагатай үйлчилгээний төрөлд багтсан бөгөөд жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-д өртсөн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг тасралтгүй хүргэж ирсэн. Улсын хэмжээнд нийт 31 НЦҮТ, хамгаалах байрууд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2017-2021 онуудад жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн бүх насны нийт 15,641 хохирогчдод нэн шаардлагатай бөгөөд

амь насыг нь хамгаалах үйлчилгээ үзүүлсэн байна. Түүнчлэн НҮБ-ын зүгээс Жендэрийн үндэсний хороо, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Сургалт, судалгааны төвийн дэргэдэх ЖСХ-ийн асуудлаарх Сургалтын танхим зэрэг жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдрэмжтэйгээр хариу арга хэмжээ авах механизмыг чадавхжуулах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж илрүүлэх, тэдэнд зохих үйлчилгээ үзүүлэх, нийгмийн эмзэг бүлгийнхэнд хүрч үйлчлэх, хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод сэтгэл зүйн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх зэрэг өргөн хүрээний асуудал хамарсан сургалтуудыг үүрэг хүлээгчдэд зориулан зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

НҮБ-аас мөн олон улсын сайн туршлага, арга аргачлалд тулгуурлан, Монголын нөхцөлд тохирсон олон нийтэд түшиглэсэн Нийгэм болоод зан үйлд гарч буй өөрчлөлт, харилцааны иж бүрэн загварыг хөгжүүлэх санаачилгыг гаргаж, ЖСХ гарахад нөлөөлж буй нийгмийн хэм хэмжээ, үндсэн шалтгааныг тодорхойлж улмаар арилгахад чиглүүлсэн. Гэсэн хэдий ч НҮБ-ын ХТХ-ний тайлант хугацаанд Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлаарх хоёр дахь удаагийн судалгаа төлөвлөгдөөгүй учир дээрх санаачилагуудын жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад үзүүлэх нөлөөг хараахан хэмжих боломжгүй байна.

Цаашлаад НҮБ-аас хүүхдийн төлөө хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад анхаарч Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх стандартыг боловсруулж, батлахад дэмжлэг үзүүлсэн. Цар тахлын үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үйл ажиллагааны стандартыг НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулж, батлуулсан. Цар тахлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээний тасралтгүй байдлыг хангасан энэхүү арга хэмжээнд янз бүрийн бүлгийн хүүхдүүд, тэр дундаа КОВИД-19-ийн халдвар авсан 146,777 хүүхэд, хамгаалах байранд түр байрлуулсан 2646 хүүхэд тус тус хамрагдсан. Түүнчлэн НҮБ-аас хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хэмжээнд хэрэгжиж буй “Мөрөөдлийн шүхэр” аяныг дэмжин, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчболжболзошгүйбайсангурваниргэнийг цагдаад мэдүүлэг өгүүлэх, сураггүй алга болсон 12 хүүхдийг олж илрүүлэн ар гэрийнхэнтэй

нь уулзуулж хүлээлгэн өгөх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон долоон монгол эмэгтэйг эх оронд нь авчрах, ирснийх нь дараа нийгэмшихэд нь туслалцаа үзүүлсний зэрэгцээ хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон гадаадын гурван эмэгтэйг эх орондоо буцахад нь туслах зэрэгт дэмжлэг үзүүллээ.

Арав шахам жил үргэлжилж буй НҮБ-ын техникийн туслалцаа, гурван талт хэлэлцээрүүд, хамтын ажиллагааны үр дүнд Хөдөлмөрийн тухай шинэ хууль 2021 оны 7-р сард батлагдсан. Тус хууль нь хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, ажил, хөдөлмөрийн нөхцөлийг зохицуулах хууль эрх зүйн орчныг сайжруулсан төдийгүй олон улсын хөдөлмөрийн стандартуудтай нийцэж байгаагаараа нэн чухал алхам болсон. Энэ нь хууль тогтоомжийн хамрах хүрээг өргөжүүлж, бүх төрлийн албадан болон хүүхдийн хөдөлмөрийг хориглох, ажлын байран дахь бүх төрлийн дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шинээр үүсч буй хөдөлмөрийн харилцааг илүү үр дүнтэйгээр зохицуулахад чиглэсэн. Түүнчлэн, НҮБ нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон улсын хөдөлмөрийн стандартад нийцүүлж, олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ажилд авах харилцаанд шударга байдлыг хангах ерөнхий зарчим, үйл ажиллагааны удирдамжийг мөрдлөгө болгон боловсруулах, гурван талт хэлэлцээрт оруулж хэлэлцэх, улмаар 2021 оны 12-р сард батлуулах зэрэг ажлуудад дэмжлэг үзүүлсэн.

НҮБ-ын зүгээс ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг хүчирхийлэл, дарамтыг арилгахад чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ирсэн. Тухайлбал, НҮБ-ын зүгээс хөдөлмөрийн орчин дахь дарамт, хүчирхийллийн нөхцөл байдал, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, төрийн албан хаагчдын дунд “Ажлын байрны бэлгийн дарамтын талаарх мэдлэг ойлголт, хандлага, өртөж буй байдал” судалгаа хийхэд дэмжлэг үзүүлсэн. Судалгааны дүнд үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс анх удаа байгууллагуудын ажилд авах харилцааг хариуцсан удирдах ажилтнуудтай нээлттэй болон ганцаарчилсан уулзалтуудыг зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага тооцох талаар нэгдсэн арга хэмжээ авах боломж бүрдсэн. Түүнчлэн НҮБ нь 2021-

2023 онд төрийн албанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Төрийн албаны зөвлөл (ТАЗ)-өөр батлуулахад дэмжлэг өгч ажиллаа.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийг боловсруулан 2021 оны 9-р сард ТАЗ-өөр батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас албан ёсоор

хүлээн зөвшөөрсөн. Улмаар 2020 оны 4-р сард батлагдсан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай хууль⁸ (КОВИД-19-ийн хууль)-ийн үйлчлэлийн хүрээнд томилогдсон төрийн албаны 1100 гаруй томилгоог хүчингүй болгосон тогтоолыг ТАЗ оны сүүлчээр баталсан.



Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар НҮБ-ын Тусгай илтгэгч Рийм Алсалем 2021 оны 12-р сард Монгол улсад айлчилсан. © НҮБ-ын Хүн амын сан / Б. Хаш-Эрдэнэ

Үр дүн 3.2 Шийдвэр гаргах түвшинд (тухайлбал, Монгол Улсын Их хурал, яамдын сайд, төрийн нарийн бичгийн дарга, аймгийн засаг дарга, иргэдийн хурлын төлөөлөгчдийн түвшинд) эмэгтэйчүүд, залуучуудын (34 хүртэлх насны) төлөөллийг нэмэгдүүлэх,

2020 оны сонгуулийн дараа орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-д эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 28 хувь хэвээр байгаа нь бүс нутгийн дундаж болох 33 хувиас доогуур байна. Шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүд, залуучуудын оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэхийн тулд ИТХ-ууд НҮБ-ын дэмжлэгтэйгээр туршин хэрэгжүүлсэн эмэгтэйчүүд, залуучууд, эмзэг бүлгийн хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх механизмыг зорилгоо болгон ашиглаж байна. Энэхүү механизмд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний аль нь ч

Хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах эрхийг баталгаажуулсны зэрэгцээ Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны дэгийг шинэчилж, хурлын тэмдэглэл болон холбогдох баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгох шаардлага тавигддаг болсон.


НҮБ-ын дэмжлэгтэйгээр “Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр”-ийг дасгалжуулах (coaching), чиглүүлэх (mentoring), манлайллын ур чадварыг хөгжүүлэх гэсэн гурван бүрэлдэхүүн хэсэгтэйгээр хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс 2021 онд төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрийг баталсан. Ингэснээр төрийн байгууллагууд энэхүү хөтөлбөрийг жил бүрийн хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөндөө албан ёсоор тусгах боломжтой болсон юм. Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүн нь хөтөлбөрт

⁸ Ковид-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (2020 оны 4 дүгээр сарын 29). Үзэх <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>

оролцогч эмэгтэйчүүд өндөр албан тушаалд өргөдөл гаргах, улмаар албан тушаал ахих тохиолдол нэмэгдэж байгаагаар илэрч байна.

Цаашдаа, 2024 оны Улсын Их хурлын сонгуульд нэр дэвших сонирхол бүхий эмэгтэй удирдагчдад мэргэжлийн туслалцаа үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилго тавьж байна. Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээг (ЭМС) эхлүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. Өнөөг хүртэл Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ нь улс төрийн янз бүрийн үзэл баримтлалтай одоогоор удирдах албан тушаал хашиж байгаа болон ирээдүйд удирдах ажил хийх хүсэл сонирхолоо илэрхийлсэн Улаанбаатар хотын 301, хөдөө орон нутгийн 268 эмэгтэйчүүд, манлайлагчдын дунд зургаан байршилд нээлтээ хийгээд байна. 2021 оны 10-р сард ЭМС нээлтээ хийснээс хойш гишүүд буюу манлайлагч эмэгтэйчүүдийн улс төрийн талаарх ойлголт, манлайлал, мэдлэгийг нэмэгдүүлэх, чадавхийг бэхжүүлэх ажил үргэлжилж байна.

Түүнчлэн залуучууд өөр хоорондоо тулгамдаж буй асуудлаа хэлэлцэх, санал бодлоо солилцох, зохион байгуулах, сурталчлах, гол асуудлаа бодлого шийдвэр гаргагчдад хүргэх зорилго бүхий оролцоог дэмжих платформыг үүсгэн ажиллуулахад нь НҮБ, Монгол Улсын Засгийн газар хамтран дэмжлэг үзүүлсэн. Энэ платформ нь Залуучуудын хөгжлийн Үндэсний Зөвлөлөөс бүрдэх бөгөөд 21 аймаг, 301 сум, Улаанбаатар хотын найман дүүрэгт залуучуудын орон нутгийн 331 салбар зөвлөл байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр зөвлөлүүд нь улс орны өмнө тулгарч буй сорилт бэрхшээлийн талаар хэлэлцэж, санал бодлоо солилцох боломжийг залуучуудад олгож байна. Үүний үр дүнд залуучуудыг эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн Засгийн газрын дэмжлэг нэмэгдэж байгаа бөгөөд залуучуудын хөгжилд зориулж улсын хэмжээнд нийт 420 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн төсвөөс хуваарилаад байна.



Мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан Хүний эрхийн магадлан шинжилгээний сургалтын үеэр.
© НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

Үр дүн 3.3 Залуучуудын холбоо, байгууллагуудыг бэхжүүлэх, тэдний үзэл бодлоо эрх тэгш түншийн хувьд чөлөөтэй илэрхийлэхийг дэмжих.

Улсын хэмжээнд 2021 оны байдлаар Залуучуудын хөгжлийн 36 төв байгуулагдсан бөгөөд залуучуудын сүлжээ ч бий болсон.

Эдгээр 36 төвийн 20 нь НҮБ-ын дэмжлэгтэйгээр байгуулагдсан төдийгүй үйл ажиллагааг нь НҮБ үргэлжлүүлэн дэмжсэн хэвээр байгаагийн зэрэгцээ тус төвүүдийн хүний нөөцийг төрөөс санхүүжүүлэхэд нөлөөлж ажилласан. Залуучуудын хөгжлийн төвүүд нь залуучуудад нийгмийн амьдралд оролцох, бусадтай харилцах, ажил, амьдралын зохистой үр чадвар эзэмших,

төрөл бүрийн зөвлөгөө авах, өөрсдийнх нь амьдралд нөлөөлж буй аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох аюулгүй орчин бүрдүүлж байгаа юм. Эдгээр төвүүдээр дамжуулан 2017 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, ажилгүй залуучууд, залуу эхчүүд зэрэг орхигдох эрсдэлтэй залуучуудыг оролцуулан нийт 152,633 залуучуудад хүрч үйлчилгээ үзүүлжээ. Залуучуудын хөгжлийн төвүүдэд залуучуудыг эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг олон нийтэд түшиглэн (хэл, онцлогт нь тааруулан) зохион байгуулж байгаагийн зэрэгцээ олон улсын “Хүүхэд, залуучууд, гэр бүлийг эрх мэдэлжүүлэх: Эрх, үүрэг хариуцлага, төлөөллийн талаарх сургагч багш нарт зориулсан арга зүйн гарын авлагыг боловсруулан түгээгээд байна. Энэхүү арга зүйн гарын авлага нь албан үүрэг гүйцэтгэгчдэд хүүхэд, залуусыг өөрсдийн гэр бүл, нутаг оронд нь эрх мэдэлжүүлэх, хүүхдийн хөдөлмөр, хүүхэд худалдаалах гэмт хэрэг, залуучуудыг хөдөлмөрийн болоод бэлгийн мөлжлөг зэрэгт өртөх эрсдэлийг хэрхэн бууруулах талаар суралцах боломж олгоно.

Ерөнхий сайдын тэргүүлдэг Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны анхдугаар хуралдаан болж, бүх шатны залуучуудын зөвлөлийн чиг үүргийн талаар хэлэлцсэн. НҮБ-аас зохион байгуулсан мэдээлэл сурталчилгааны ажлын үр дүнд залуучуудын хөгжлийг дэмжих зорилгоор салбарын бүх яамд залуучуудын асуудлаарх ажлын хэсэг

байгуулсан. Түүнчлэн НҮБ болон ХНХЯ хамтран Залуучуудын хөгжлийн үндэсний VII чуулга уулзалтыг зохион байгуулж, холбогдох яамд, төр засгийн байгууллага, төрийн бус байгууллага, залуучуудын төлөөллийг оролцуулсан.

НҮБ нь Сонгуулийн Ерөнхий Хороо, ХНХЯ-тай хамтран мэдээлэл нотолгоонд тулгуурласан, идэвхи санаачлагатай залуу сонгогчдын үйл хэрэг, залуучуудын үзэл бодлоо илэрхийлэхийг дэмжих зорилгоор залуу сонгогчдын боловсролыг дээшлүүлэх хоёр төрлийн сургалтын жендэрийн мэдрэмжтэй хөтөлбөрийг боловсруулсан. Эдгээр хоёр төрлийн сургалтын хөтөлбөрийг 2022 онд улсын хэмжээнд хэрэгжүүлнэ.


КОВИД-19 цар тахлын нөхцөлд ч залуучууд НҮБ-аас хэрэгжүүлсэн хөгжлийн болоод хүмүүнлэгийн үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцож байлаа. Цар тахал дэгдсэнээс хойш 1114 сайн дурын ажилтан залуус хүүхэд хамгааллын үйлчилгээ, КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажил зэрэгт идэвхтэй ажилласан. Түүнчлэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хэрэгжүүлсэн сэтгэцийн эрүүл мэнд, хүүхэд хамгааллын асуудлаар кампанит ажлыг зохион байгуулсан сайн дурынхны үйл ажиллагаанд НҮБ дэмжлэг үзүүлсэн. Нийт 400 гаруй залуу сайн дурынхан “Ухамсараас үйлдэлд: оюун бодлоо эрүүл байлгая” (From Awareness to Action: let's keep our mind healthy) цахим аянд шууд хамрагдаж, нутаг орондоо өөрсдийгөө



халамжлах, дэмжих бүлгүүдийг байгуулан сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах тухай мессеж, үйл ажиллагаагаараа 90,000 гаруй хүнд хүрч ажилласан. Түүнчлэн цэвэр агаар санаачилга, сургуулиудын ус, ариун цэвэр, эрүүл ахуйг сайжруулах, охидын сарын тэмдгийн үеийн эрүүл ахуй зэрэг бусад чухал асуудлуудад залуучуудын оролцоог өргөжүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлсэн. Эдгээр үйл ажиллагаанд 1277 сайн дурын ажилтан залуус хамрагдаж, өөрсдийн шууд үйл ажиллагаа, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Уур амьсгалын өөрчлөлт, цэвэр агаарын асуудлаарх залуучуудын сүлжээ (YouCCAN) зэргээр дамжуулан 22,925 хүнд хүрч үйлчлээд байна.

Эрэгтэй, эмэгтэй залуусын хөдөлмөрлөх эрхийг дэмжих зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Залуучуудын зохистой хөдөлмөрийн төлөөх сүлжээ байгуулагдсан. Хөдөлмөрийн тухай шинэ хууль батлагдсанаар тус сүлжээ нь залуучуудын хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг идэвхтэй сурталчлах болсон.

Макро эдийн засгийн хариу арга хэмжээ ба олон талт хамтын ажиллагаа



2.2.4 2021 ОНД ТУЛГАРСАН СОРИЛТ БЭРХШЭЭЛҮҮД

- КОВИД-19-ын цар тахлын үеийн хорио цээр, хязгаарлалтын дэглэм, олон нийтийг хамарсан арга хэмжээ, уулзалт цуглаан, дотоодын аялал зэрэгт тавьсан хязгаарлалтууд нь мэдээлэл сурталчилгаа, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, хяналт шинжилгээ, үнэлгээг үндсэн нэгжид очиж хийх гэх мэт төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулахад саад тээг болж байсан.
- КОВИД-19-ийн үеийн хүндрэл, онцгой байдлын үетэй давхцан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байсан нь хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх цаг хугацаа, үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байсан.
- Цар тахлын дэгдэлт, түүнээс сэргийлсэн хязгаарлалтын арга хэмжээнүүд хэрэгжих үеэр жендэрт суурилсан хүчирхийлэлболон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгэм-эдийн засгийн олон асуудлыг улам бүр хурцатгасан.



Намаржаандаа буухаар нүүж буй малчин айл. © НҮБ-ын СЗГ / Д.Соёлмаа

2.3 2030 ОНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ТҮНШЛЭЛИЙГ ДЭМЖИХ

Монгол Улсын Их Хурлаас 2021 онд Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөл (ТХОТЗ)-ийг байгуулахад НҮБ-ын зүгээс дэмжиж ажилласан. 2021 оны 10-р сарын 4-нд зохион байгуулагдсан Тогтвортой хөгжлийн зорилго-Үндэсний дээд түвшний чуулганы үеэр УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар хамтран ТХОТЗ байгуулагдсаныг албан ёсоор зарласан. ТХОТЗ-д хоёр болон олон талт хөгжлийн түншүүд, Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшлийнхний төлөөлөл орсон. ТХОТЗ-ийн гол зорилго нь ТХЗ-ыг үндэсний хөгжлийн төлөвлөлт, санхүүжилт, хяналт шинжилгээний тогтолцоонд тусгах замаар Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд оршино.

КОВИД-19 цар тахалтай хамтын хүчээр тэмцэх хариу арга хэмжээний түншлэл

Дэлхий дахиныг, тэр тусмаа Монгол Улсыг хямралд хүргэж байсан КОВИД-19 цар тахлын хүнд үед НҮБ-ын системийн хүрээнд төдийгүй бусад гол түншүүдийн хувьд зохицуулалт, төлөвлөлт тун чухал байсан. Тухайлбал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын манлайлал, техникийн тусламжтайгаар КОВИД-19-ийн эсрэг вакцинцуулалтад бэлтгэх төлөвлөлт, зохицуулалтын механизмыг бүрдүүлж чадсан.

Эрүүл мэндийн сайдаар ахлуулсан Үндэсний зохицуулах хороог байгуулж, бүрэлдэхүүнд нь ЭМЯ, Халдварт өвчин судлалын төв, Гадаад харилцааны яам, НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБ-ын ХС), Дэлхийн банк, ДЭМБ-ын төлөөлөл орж ажилласан. Тус хорооны гишүүдийн үндсэн үүрэг нь үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийн хэрэгжилтэд ерөнхий хяналт тавьж удирдлагаархангах, КОВИД-19 цар тахлын эсрэг вакцинжуулалтын хөтөлбөрийг үндэсний болон олон улсын хандивлагч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх явдал байв. Түүнчлэн ДЭМБ болон НҮБ-ын системийн бусад байгууллагуудын техникийн туслалцаатайгаар Шадар сайдын удирдлага дор сайн туршлага, гол сорилтуудыг тодорхойлж, цаашид сайжруулах боломжуудыг санал болгох КОВИД-19-ийн хариу арга хэмжээний дотоод үнэлгээг үндэсний хэмжээнд зохион байгуулж ажилласан. Хувийн хэвшлийг КОВИД-19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд татан оролцуулахын тулд НҮБ-ын Хүн амын сан (НҮБ-ын ХАС) нь хамгийн том

уул уурхайн компани болох Рио Тинто ХХК-тай түншийн холбоог амжилттай тогтоож иж бүрэн тоноглогдсон Полимеразын гинжин урвал (ПГУ)-ын 4 лаборатори байгуулах санхүүжилтийг авч, КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр тэргүүн шугамд ажиллаж буй ажилтнуудыг хамгаалах хэрэгслээр хангах, ПГУ-ын технологийг ашиглах лабораторийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлсэн. Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), НҮБ-ын ХС, ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Улсын Онцгой комиссын манлайлал дор олон нийтийг цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлсэн “Гараа угаа, маскаа зүү” үндэсний аяныг зохион байгуулсан бөгөөд энэ аянд 1.7 сая гаруй хүн хамрагдсан. Түүнчлэн ОУШХБ, НҮБ-ын Суурин зохицуулагчийн алба, НҮБ-ын ХС, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын ХАС, ДЭМБ, НҮБ-ын ХХААБ, Швейцарын хөгжлийн агентлаг, Монголын улаан загалмай нийгэмлэг, Монгол Улсын Засгийн газар хамтран КОВИД-19-ийн халдвар авсан анхны тохиолдол, бусад хүмүүсийг гутаан доромжлохын эсрэг тэмцэх, мөн эмч, цагдаа зэрэг тэргүүн шугамд ажиллаж байгаа хүмүүсийг тууштай дэмжих зорилгоор “Дэмжье, талархья” аяныг зохион байгуулсан.

Стратегийн түншлэлд түшиглэн санхүүжилтийн нэгдсэн стратегийг боловсруулах

2030 он гэхэд ТХЗ-той уялдсан үндэсний хөгжлийн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний нэмэлт санхүүжилт шаардлагатай болно. Энэхүү санхүүжилтийн дутууг нөхөхийн тулд дотоодын болон олон улсын зах зээлээс нэмэлт санхүүгийн эх үүсвэрийг дайчлах, төлөвлөлт, төсөвлөлт, санхүүжилтийн үйл явцыг бэхжүүлэх, өнөөгийн санхүүжилтийн хуваарилалтаа ТХЗ-той нягт уялдуулах зайлшгүй шаардлага байна. Нэмэлт санхүүжилтийн хэрэгцээг шийдвэрлэхийн тулд Монгол Улс дахь НҮБ-ын ТХЗ-ын Хамтарсан сангийн хөтөлбөрийн хүрээнд 2021 онд Европын Холбоо, ДБ, Олон улсын валютын сан, Азийн Хөгжлийн банк, Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, НҮБ зэрэг олон тооны түншүүдтэй хамтран НҮБ-ЫН ХХ-ийн техникийн дэмжлэгтэйгээр Үндэсний нэгдсэн санхүүжилтийн стратеги

(ҮНСС)-ийн анхны төслийг боловсруулснаар ихээхэн ахиц дэвшил гарсан. ҮНСС)-ийн төслийг Монголын тогтвортой санхүүжилтийн чуулганы үеэр Сангийн яамнаас танилцуулсан. Түүнчлэн Үндэсний нэгдсэн санхүүжилтийн стратеги нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тусгасан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хүндрэлийг даван туулах нэгдсэн бөгөөд олон талт стратегийн алхмуудыг тодорхойлохын зэрэгцээ хяналт шинжилгээ, тайлагнал, засаглал, зохицуулалтын механизмыг сайжруулахад чиглэнэ.

Үндэсний нэгдсэн санхүүжилтийн стратеги нь байгууллага хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа, зохицуулалтыг илэрхийлэхийн зэрэгцээ хамгийн орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдэд хүрч чадахаараа онцлог юм. Үндэсний нэгдсэн санхүүжилтийн стратегийг боловсруулах ажлын хүрээнд НҮБ-ын ХС-гаас хүүхдэд чиглэсэн нийгмийн салбарын төсвийн зарлагын үнэлгээг хийсэн нь нотолгоонд суурилсан тоо мэдээллийг бий болгох, засгийн газрын төсөв боловсруулах үйл явцад хүүхдийн асуудлыг илүү тодорхой тусгах, хүүхдэд зориулсан төсвийн зарлагын үр нөлөөг бэхжүүлэх зэрэгт хувь нэмэр оруулах болно. НҮБ-ын ХХ-ийн өөр нэг төслийн хүрээнд БШУЯ-тай хамтран Боловсролын салбарын төсвийн зарлагын үнэлгээг хийсэн. Энэхүү ажилд суурилж НҮБ-ын дэмжлэгтэйгээр тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв боловсруулах гарын авлагын төслийг боловсруулах ажил

хийгдэж байна. Эцэст нь НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран залуучуудын хөгжил, оролцоонд зориулсан зардлын үнэлгээг хийсэн.

Олон улсын санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаа

НҮБ-ын Удирдлагын баг/Суурин зохицуулагч болон олон улсын санхүүгийн байгууллагын суурин төлөөлөгчид хоорондын нягт хамтын ажиллагаа, тус оронд үйл ажиллагаа явуулж байгаа хөгжлийн түншүүдээр дамжуулан Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг, ялангуяа, НҮБ-ын ХХААБ, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ нь Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж байна. Монгол Улсад суурин төлөөлөгчийн газаргүй НҮБ-ын АҮХБ нь Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны хүсэлтээр Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциациас санхүүжүүлж буй “Монгол Улсын Экспортыг дэмжих төсөл”-ийн 3 дахь бүрэлдэхүүн хэсэг болох “Жижиг, дунд агро-үйлдвэрүүдийн экспортын өрсөлдөх чадварыг өргөжүүлэх Баталгаажуулалтын үйлчилгээ, чанарын удирдлагыг сайжруулах” төслийг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүллээ. Экспортыг дэмжих төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын уул уурхайн бус салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрүүдэд зах зээлийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх замаар тэдний экспортын чадавхийг бэхжүүлж, экспортын зах зээлд нэвтрэх



Тогтвортой ноолуурын платформд хамрагдаж, үр шимийг нь хүртэж буй малчин эмэгтэй. © НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр



боломжийг өргөжүүлэхэд оршиж байгаа юм. Энэ нь дотоод, гадаадын худалдан авагчдад хүлээн зөвшөөрөгдөхүйц хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний тохирлын үнэлгээ, чанарын баталгаажуулалтын үйлчилгээг хөгжүүлэх хэрэгцээг бий болгоно. НҮБ-ын АҮХБ-ын Агро-бизнесийн газрын Тогтвортой хүнсний системийн хэлтэс нь холбогдох бусад газар хэлтэсүүд, төв болон БНХАУ дахь бүс нутаг хариуцсан байгууллагуудтайгаа хамтран Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг удирдан чиглүүлж байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэл

Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) нь нийгмийн бүх түвшинд тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэн бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй ТХЗ-ын санхүүжилтийн дутууг нөхөхөд амин чухал юм. НҮБ-ЫН ХХ-ийн манлайллаар Монгол Улсад ноолуурын үйлдвэрлэл зэрэг олон салбарт ТХХТ-ийг хөгжүүлэхэд НҮБ зохицуулагч, зуучлагчийн үүргийг идэвхтэй гүйцэтгэж ирсэн. 2021 онд Монгол Улсын Тогтвортой ноолуурын платформ (механизмыг үүсгэж засгийн газар, хувийнхэвшил(олонулсынзагварынбрэндүүдийг оролцуулаад), иргэний нийгмийн байгууллагууд, малчдын бүлгүүдийн төлөөллийг нэгдэж ажиллах нөхцөлийг бүрдүүлснээрээ Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь өөр өөр ашиг сонирхол бүхий бүлгүүдийг зөвшилцөлд хүргэх чадвартайгаа харуулсан билээ. Энэхүү платформд Кашмер Холдинг, Ханбогд кашмер, МонИтал, ШинэИдэр, Гоёл, Хатант Интернэшнл ХХК, Монголын ноос ноолуурын холбоо, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн

холбоо, Тогтвортой ширхэглэгийн холбоо (Sustainable Fibre Alliance) оролцож байна. НҮБ-ын ХС нь тус улсад үйл ажиллагаа явуулж буй томоохон компаниудын дунд гэр бүлд ээлтэй бодлогыг идэвхтэй сурталчилж, Монгол Улсад бизнесийн хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна. УИХ-аас Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, Монгол Улсын гэр бүлд ээлтэй бодлогуудад жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн заалтуудыг тусгаснаар хөдөлмөр эрхэлж буй гэр бүлд аз жаргалтай, эрүүл хүүхэд өсч торних орчныг сайжруулахад ахиц дэвшил гарсан.

Дижитал хувьсал, эрс шинэчлэл, технологи

НҮБ нь Дижитал үндэстэн болох Монгол Улсын үндэсний стратегийг боловсруулах чиглэлээр шинэхэн байгуулагдсан Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам, хувийн хэвшлийнхэн, олон улсын санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагууд, тухайлбал, НҮБ-ын ХХ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын ХС, ДЭМБ, Олон улсын хөгжлийн хуулийн байгууллага нь Засгийн газар, Дэлхийн банк болон бусад хөгжлийн түншүүдтэй хамтран дижитал бичиг үсгийн боловсрол, кибер аюулгүй байдал, КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ, эрүүл мэнд зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулахдаа залуучуудын оролцоо, манлайлалд түлхүү анхаарч ирсэн. Ялангуяа КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээнүүдэд Монгол Улс дахь НҮБ нь дижитал шинэчлэл, технологийг ашиглаж орхигдох эрсдэлтэй нэн эмзэг хүн амын бүлгүүдэд анхаарлаа чиглүүлж ажилласан.



Дижитал үндэстэн форумгаар цахим хөгжилд өсвөр, залуу үеийнхний оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдний дуу хоолойг сонсов. © ЦХХХЯ.

Тухайлбал, НҮБ-ын ХХ-өөс КОВИД-19 цар тахлын халдвараас шалтгаалж амь нас, амьжиргаанд нь аюул тулгарч байсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмзэг бүлгийнхэнд илүү шуурхай туслах зорилгоор Монгол Улсад анх удаа нийгмийн ажилтнуудад зориулсан тохиолдлын (кейс) дижитал удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд техникийн тусалцаа үзүүлж, цар тахлын үед нийгмийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд нь Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн. Энэ талаар Үр дүн 1.1.4-т өгүүлсэн болно.

Тус улсын харилцаа холбооны томоохон компани болох Юнител ХХК нь НҮБ-ын ХАС-д мөнгөн бус дэмжлэг үзүүлэх тухай түншлэлийн гэрээ байгуулж Мандухай маркетинг болон Эх, нялхасын эрүүл мэндийн төвийн шуурхай дуудлагын утасны үйлчилгээг зохион байгуулсан. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд хиймэл оюун ухаант, өсвөр үеийнхний цахим зөвлөх

Мандухай чатбот үйлчилгээг орон даяар нийт залуучууд, өсвөр үеийнхэн ашиглах боломжийг бүрдүүлсэн.

НҮБ-ын ХС, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС хамтран КОВИД-19 цар тахлын улмаас сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа зогссон үеэр боловсролын үйлчилгээг тасралтгүй үргэлжлүүлэх зорилгоор хүүхдүүдэд зориулсан дижитал сургалт явуулах санаачилгыг хэрэгжүүлсэн. НҮБ-ын энэхүү хамтарсан санаачилгаар Монгол Улсын сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын салбарт анх удаа дижитал сургалтын шийдлийг нэвтрүүлсэн. Түүнчлэн НҮБ-ын ХС -гаас малчдын хүүхдүүдэд болон телевиз, интернетийн боломжгүй хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн аудио контент бүтээх хөтөлбөрийг санаачилсан. Энэ хүрээнд 600,000 гаруй хүүхэд интерактив болон аудио контент-д хандаж ашигласан байна.

Кейс судалгаа: mHealth технологийн дэмжлэг – ДЭМБ болон бусад түншүүд

“Эрүүл мэндийн төвүүдийн түвшинд эрүүл мэндийн мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх” санаачилга Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт хэрэгжиж байна. Энэхүү санаачилгыг 2016 онд 22 ЭМҮТ-д эхлүүлж, 5 жилийн хугацаанд төв, орон нутгийн засаг захиргааны хүчин зүтгэлээр 302 буюу нийт ЭМҮТ-ийн 56%-д хүрч өргөжсөн байна.

Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг удирдлага болгон хүн төвтэй эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг эмзэг бүлгийнхэн, тус улсын алслагдсан бүс нутаг, хот орчмын бүс нутагт амьдарч буй хүмүүст хүргэх стратегийг боловсруулсан.

ЭМЯ, орон нутгийн засаг захиргаад, аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхэн зэрэглөл салбарын оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж түншлэлийн сайн харилцаа тогтоосон нь хүн төвтэй эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэхэд хувь нэмэр оруулсан. Энэхүү санаачилгыг ДЭМБ, олон улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний БНСУ-ын сан, Солонгосын олон нийтийн сан, Европын холбоо, Австрали улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Оюу Толгой ХХК зэрэг олон улсын байгууллагууд, дэмжин ажиллаж байна.

2.4 НҮБ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН: НҮБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦАН УЯЛДАА ҮР ДҮН, НӨЛӨӨ

НҮБ-ын бүтцийн шинэчлэлийн хүрээнд 2021 оноос Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн шинэчлэгдсэн алба НҮБ-ын Удирдлагын багт үйлчилж эхэлсэн.

Нэгдмэл бодлого, зохицуулалттай байх, бүх нийтийн оролцоог хангаж цогц байх хандлагыг НҮБ-ын Суурин зохицуулагчийн зүгээс идэвхтэй сурталчлан таниулсны үр дүнд Монгол Улсын Засгийн газрын тогтвортой хөгжлийн асуудлыг удирдан зохицуулах дээд байгууллага болох Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Тогтвортой хөгжлийн үндэсний хороо (ТХҮХ) шинэчлэн байгуулагдсан. Шинэчлэгдсэн ТХҮХ-ны бүрэлдэхүүнд НҮБ-ын Суурин зохицуулагч орсон нь НҮБ, Монгол Улсын Засгийн газар хоорондын тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн төлөөх стратегийн хамтын ажиллагааг илүү өргөжүүлэх боломж нээгдсэн. Олон жил хүлээгдэж буй Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтүүдийн төслийг болосвруулан тус зөвлөлөөр хэлэлцэн дэмжсэн бөгөөд батлуулахаар УИХ-д өргөн мэдүүлээд байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар, НҮБ хамтран Тогтвортой хөгжлийн зорилго-Дээд түвшний чуулга уулзалтыг Монгол Улсад анх удаа зохион байгуулж Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх 10 жилийн

Үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хамтын хүчин чармайлтуудаа тодорхойлсон.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Их Хурал, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллага, хөгжлийн түншүүд зэрэг олон салбарын төлөөллөөс бүрдсэн тогтвортой хөгжлийн төлөөх олон талт платформыг (Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөл -ТХОТЗ) байгуулсан. УИХ манлайлах энэхүү өндөр түвшний платформ нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, нэгдмэл бодлого зохицуулалтыг хангах, тэдгээрийн санхүүжилт, үр дүнд хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн үзэж байна.

Монгол Улсад ТХЗ-ыг хэрэгжүүлэх дунд хугацааны 10 жилийн зорилтот хөтөлбөрүүд, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” зэргийг боловсруулахад НҮБ-аас зохицуулалттайгаар дэмжлэг үзүүлсэн бөгөөд НҮБ-ын системийн байгууллагууд тус тусын чиглэлээр бүрэн эрхийнхээ хүрээнд техникийн туслалцаа үзүүлж байна.

НҮБ-ын Суурин зохицуулагчийн манлайлал дор Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг нь манлайллын шинэ чадавхийг хөгжүүлэх



ТХЗ-ын үндэсний дээд түвшний анхдугаар чуулганд УИХ-ын дарга Г. Занданшатар үг хэлж, ТХЗ-ыг хэрэгжилтийг хурдасгах шаардлагатайг уриалав. © НҮБ-ын СЗГ

аргуудыг турших, системийн сэтгэлгээ, эрс шинэчлэл хийх, өөрчлөлтийг удирдан чиглүүлэх арга хандлагын практик хэрэглээний талаарх ойлголт, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн зохицуулалтын албанаас дэвшүүлсэн ТХЗ-ын Манлайлал хөтөлбөрийн олон улсын санаачилгад нэгдсэн дэлхийн 14 орны нэг болсон юм.

НҮБ-ын Суурин зохицуулагчийн удирдлага дор Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг нь НҮБ-ын хамтарсан гурван хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх замаар Монгол Улсын Засгийн газрыг дэмжиж ажилласан. Үүнд:

- КОВИД-19-ын цар тахалтай тэмцэх Үндэсний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, цар тахлын үед боловсрол, эрүүл мэндийн нэн чухал үйлчилгээг тасралтгүй хүн амд хүргэх;
- ТХЗ-ын санхүүжилтийн стратегийг боловсруулах;
- Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, орлого нэмэгдүүлэх чадавхийг хөгжүүлэх, малчдын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд институцижуулах зэргээр үндэсний хэмжээний мэдээлэл сурталчилгааны туршилтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар залуу малчдад зориулсан гарааны бизнесийн загварыг хөгжүүлэх;

НҮБ-ын Удирдлагын баг нь Интернетэд суурилсан UNInfo платформыг ашиглан НҮБ-ын ХТХ-ний үр дүнгийн зорилтуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж ирсэн.

НҮБ-ын Удирдлагын баг нь үйл ажиллагаагаа үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтуудтай уялдуулан үрдүнтэй хамтынажиллагааг өрнүүлж, хамтын зорилтоо амжилттай хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн үнэлгээнээс харахад хөгжлийн хөтөлбөрүүдийн үр дүн, үр нөлөөг илүү сайжруулах илүү боломж байна. 2021 онд тус улсын ТХЗ-ын хэрэгжилт, сорилт бэрхшээл, тэргүүлэх зорилтуудыг задлан шинжилсэн Монгол Улсын Төлөв байдлын шинжилгээний үр дүнд суурилж одоо боловсруулж байгаа 2023-2027 онд хэрэгжүүлэх НҮБ-ын ТХХАХ-ний шинэ хөтөлбөрүүдийг үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтуудтай нягт уялдуулан нийцүүлэх ажлаа үргэлжлүүлнэ.

НҮБ-ын Удирдлагын баг нь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт зэрэг салбар дундын асуудлуудад анхаарлаа хандуулж мэдээлэл, харилцаа холбоо, нөлөөллийн хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ. НҮБ-ын Мэдээлэл харилцааны баг нь ТХЗ-ыг сурталчлан таниулахад онцгой анхаарал хандуулсан хэд хэдэн хамтарсан мэдээлэл харилцааны кампанит ажлыг удирдан зохион байгуулсан.

Бизнесийн үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах зорилгоор Захиргааны удирдлагын баг нь Бизнесийн үйл ажиллагааны стратегийг боловсруулж бизнес аялалын үйлчилгээ, барилга, байгууламжийн засвар үйлчилгээ, хамгаалалтын үйлчилгээ, хэвлэл нийтлэлийн үйлчилгээ, зочид буудал, хүлээн авалтын үйлчилгээ, орчуулгын үйлчилгээ, тээврийн хэрэгслийн түрээсийн үйлчилгээ зэрэг нийтлэг үйлчилгээний урт хугацааны хамтын гэрээ байгуулан ажиллаж байна. Бизнесийн үйл ажиллагааны стратегийг боловсруулан хэрэгжүүлэхэд хамтран ажиллаа. Ингэснээр ажилтнуудын цаг, хүчийг илүү үр дүнтэй ашиглах, худалдан авалтын үйл явцын үргэлжлэх хугацааг богиносгосон, түүнчлэн жижиг нэгжүүдэд худалдан авалтын үйлчилгээ үзүүлэх зэргээр захиргааны зардлыг хэмнэхэд хувь нэмэр оруулж байна.

Нэгдэж ажиллах арга барилыг нэвтрүүлснээр Захиргааны удирдлагын баг нь Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагуудыг нэг байранд байрлуулах төлөвлөгөөг хэрэгжүүлж улмаар төслүүдийг ч нэр дор төвлөрүүлэн байрлуулах талаар төлөвлөн ажиллаж байна. Ийнхүү нэгдсэн төлөвлөгөө гаргаж ажилласнаар албан байрнуудын нөхцөл байдал, төслүүдийн албан байрны нөхцөл байдал, нийтлэг үйлчилгээг хамтран ашигласнаас гарах үр ашгийн талаар үнэн зөв мэдээллийг өгнө.

2.5 ҮНЭЛГЭЭ, СУРГАМЖ

2017-2022 онд хэрэгжүүлж байгаа НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБХТХ)-ний хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын хамтарсан Удирдах хорооны захиалгаар 2021 оны 8-р сараас 2022 оны 2-р сарын хооронд Монголын Хараат бус судалгааны хүрээлэн (/IRIM) хөндлөнгийн үнэлгээ хийсэн. Тус үнэлгээг НҮБ-ын ХТХ-ний а) Хамааралтай байдал, хэрэгцээнд нийцсэн байдал; б) Үр дүнтэй байдал; в) Тогтвортой байдал, нөлөөлөл; г) НҮБ-ын системийн байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалт; д) Үр нөлөө; е) Салбар дундын асуудлыг шийдвэрлэх зарчмууд зэрэг асуудалд үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон. Энэ хэсэгт үнэлгээний гол үр дүн, дүгнэлт, зөвлөмжүүдийг жишээ болгон орууллаа. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү.

2.5.1. Үнэлгээний гол үр дүн, дүгнэлт

Хамааралтай байдал

НҮБ-ын ХТХ нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн үзэл санааг сайтар тусгасан Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-тай нийцсэнийг баримт нотолгоо илэрхийлж байна. НҮБ нь тус улсад шинээр бий болсон буюу урьдчилан тооцоолоогүй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа зохицуулж байжээ.

Үр дүнтэй байдал

НҮБХТХ-ний зарим шалгуур үзүүлэлтүүдийг НҮБ-ын хувь нэмрийг үнэлэхэд хэт өндөр буюу амбицтай тодорхойлсон байгаа нь хөтөлбөрүүдийн үр дүнд нухацтай хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ) хийх боломжийг хязгаарлаж байна. Дараагийн НҮБ-ын ТХХАХ-г боловсруулахдаа НҮБ-ын оруулах хувь нэмрийг нарийн тодорхойлж, үр дүнгийн зорилтууд, үр дүн, шалгуур үзүүлэлтүүд, зорилтот түвшинг бодитой, хэмжигдэхүйц байхаар тодорхойлох шаардлагатай.

Тогтвортой байдал, нөлөөлөл

Үнэлгээний тайланд НҮБ-ын ХТХ-ний үр дүнгийн гурван зорилтын хүрээнд хүрсэн үр дүнг дэлгэрэнгүй тусгасан. НҮБ-ын ХТХ-нд эхлүүлсэн хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг үндэсний оролцогч талууд дэмжиж хэрэгжүүлсэн, өргөжүүлэн хөгжүүлсэн олон тодорхой жишээ байна. Гэсэн хэдий ч хөрөнгө нөөцийн

хүрэлцээгүй байдал, төсөл хөтөлбөрийн цар хүрээг өргөжүүлэх, үргэлжлүүлэх тодорхой стратеги үгүйлэгдэж байгаа нь тодорхой хугацааны дараа НҮБ-ын ХТХ-ний үр өгөөжийг бууруулж, цаашид үргэлжлэх боломжийг хязгаарлаж болзошгүй юм. НҮБ-ын ХТХ-г боловсруулж эхлэх мөчөөс эхлэн Засгийн газрыг оролцуулах нь НҮБ-ын ХТХ-г үндэсний хөгжлийн зорилтуудтай уялдуулах, тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ. НҮБ-ын ХТХ нь хүмүүсийн амьдралд бодитой нөлөө үзүүлж, хүний эрх, амьдрах орчныг хамгаалахад дорвитой өөрчлөлт гаргахад чиглэгджээ.

НҮБ-ын системийн байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалт

Цөөн хэдэн хамтарсан төслүүдийг эс тооцвол НҮБ-ын ХТХ нь НҮБ-ын системийн байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнтэй, стратегийн хэрэгсэл болж хараахан чадаагүй байна. Гэхдээ НҮБ-ын ХТХ нь НҮБ-ын системийн нийт байгууллагуудын ерөнхий чиглэлийг тодорхойлж, ямар байгууллагууд хамтарсан ямар төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх оролдлого хийснийг харах боломж олгож байна. НҮБ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын гол цөм болгон ТХЗ-ыг хэрэгжүүлэхийг сурталчлан таниулах замаар төр засгийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулжээ. НҮБ-ын Удирдлагын баг нь Хөгжлийн хамтын ажиллагааны албанаас зөвлөмж болгосон НҮБ-ын ХТХ-г боловсруулах удирдамжийн дагуу НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд ашиглах Хамтарсан ажлын төлөвлөгөө боловсруулаагүй байна.

Үр нөлөө

Захиргааны удирдлагын баг нь худалдан авалтын нийтлэг үйлчилгээг илүү хөнгөвчилсөн байдлаар зохион байгуулж байгаа нь үйл ажиллагааны зардлыг бууруулж захиргааны зардлыг ихээхэн хэмжээгээр хэмнэх боломжийг бүрдүүлжээ.

Төрийн болон төрийн бус түнш байгууллагуудтай хийх бэлэн мөнгөний гүйлгээний нийтлэг үйлчилгээний нэгдсэн тогтолцоог Бэлэн мөнгө шилжүүлэхэд мөрдөх журамаар зохицуулж байгаагийн үр дүнд гүйлгээний зардал буурчээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх

НҮБ-ын ХТХ-г боловсруулах, үр дүнгийн зорилтуудыг тодорхойлж хэрэгжүүлэх бүхий л үйл явцад, ялангуяа, үр дүнгийн зорилт 3-ыг тодорхойлоход жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх асуудлыг тусгасан байна. НҮБ-ын мэдээллийн сан (UN-INFO)-гийн жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрхэн тусгасан байдлыг авч үзэхэд НҮБ-ын ХТХ-ний нийт хөтөлбөрийн 94 хувь нь 2017-2020 онуудад жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар тодорхой арга хэмжээнүүдийг тусгажээ.

Хүний эрхэд суурилсан хандлага

НҮБ нь хүний эрхийн асуудлаар үзэл санаагаа тууштай илэрхийлдэг байгууллагуудын нэг бөгөөд хүний эрхийн конвенцийг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсад дэмжлэг үзүүлж байна. НҮБ-ын ХТХ нь хүний эрхийн асуудалд онцгой анхаарал хандуулахын зэрэгцээ Монгол Улсын олон улсын болон бүс нутгийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэхэд нь хувь нэмрээ оруулж байна. Гэхдээ НҮБ-ын ХТХ-г хэрэгжүүлэх явцад Хүний эрхэд суурилсан хандлага, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг болон хүний эрхийн бусад механизмуудаас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг Монгол Улс хэрхэн хэрэгжүүлж байгаад дорвитой анхаарал хандуулж чадаагүй байна.

Хэнийг ч орхигдуулахгүй байх

Өнөөгийн хэрэгжүүлж байгаа НҮБ-ын ХТХ нь “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг хэрэгжүүлэхэд чиглүүлж орхигдох эрсдэл бүхий эмзэг бүлгийг нарийвчлан тодорхойлоогүй байна. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, Лесбиян, гей, бисексуал, трансжендер хүмүүс, үндэстний цөөнх, эрхээ хязгаарлуулж шоронд хоригдож буй хүмүүс зэрэг хүн амын бүлгүүдийг НҮБ-ын төсөл, хөтөлбөрүүдэд дорвитой хамруулж чадаагүй байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл зэрэг эмзэг асуудал ч мөн үүнд хамаарна. Эдгээр эмзэг асуудлыг Засгийн газар, хөгжлийн түншүүд, эрдэм шинжилгээний байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор шийдвэрлэх шаардлагатай байна. Түүгээр ч барахгүй, ядуурал, тэгш бус байдал КОВИД-19 цар тахлын үед улам бүр хурцдаж байгаа учир эмзэг байдлыг илүү олон талаас нь судалж анхааралдаа авах

шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог дэмжих асуудлыг төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд хэлэлцэж байгаа хэдий ч хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилт тодорхойгүй байна. Энэ асуудлаар байгууллага дундын ажлын хэсэг байгуулагдсан байна. Байгууллага бүр өөрийн эрх үүргийн хүрээнд тодорхой чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх

Хөтөлбөр, төслүүдийн хүрээнд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар хэлэлцэж байгаа хэдий ч мөн л хэрэгжүүлэх түвшинд хамтын ажиллагаа сул байна. НҮБ-ын ХХ нь хэд хэдэн төслүүддээ нийгэм, байгаль орчны стандартыг мөрдөж байна.

2.5.1. Зөвлөмж

Тэргүүлэх ач холбогдол бүхий зөвлөмжүүд:

1. НҮБ-ын Удирдлагын баг болон Засгийн газар нь дараагийн Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБ-ын ТХХАХ)-г тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх хамтын алсын хараа, эрхэм зорилго болгон хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгох;
2. Дараагийн НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд Засгийн газар эзний ёсоор хандаж, стратегийн удирдлагаар хангаж ажиллах;
3. НҮБ-ын Суурин зохицуулагч/НҮБ-ын Удирдлагын багийн манлайлал дор НҮБ-ын системийн нийт байгууллагууд НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхийн зэрэгцээ Үр дүнгийн бүлгүүд, Сэдэвчилсэн багуудын нягт хамтын ажиллагааг сайжруулж ТХХАХ-г стратегийн түвшинд удирдахад нь НҮБ-ын Удирдлагын багт дэмжлэг үзүүлэх;
4. НҮБ-ын Суурин зохицуулагчийн манлайлал дор НҮБ-ын Удирдлагын баг нь “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчим, хүний эрхэд суурилсан хандлагыг НҮБ-ын ТХХАХ-ний удирдах зарчимд тусгаж хэрэгжүүлэх;
5. НҮБ-ын Удирдлагын баг нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэхийг НҮБ-ын ТХХАХ-ний удирдах зарчимд тусгаж хэрэгжүүлэх;

6. НҮБ-ын Удирдлагын баг болон Засгийн газар нь дараагийн НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэх санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн зохистой механизмыг бий болгож нөлөөллийн цар хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай.

Дунд түвшний ач холбогдол бүхий зөвлөмжүүд:

1. НҮБ-ын Удирдлагын баг нь НҮБ-ын ТХХАХ-ний үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд дэвшүүлж буй үр дүнгийн зорилтуудын хүрээнд олон салбарын оролцогч талуудын түншлэл, стратегийн хамтын ажиллагааг дэмжих;
2. НҮБ-ын Удирдлагын баг нь хамтарсан зорилтот төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж, хөрөнгө санхүүжилт төвлөрүүлэх шаардлагатай. Ингэхдээ НҮБ-ын төсөл хөтөлбөрүүд нь газар зүй, байршлын хувьд хүртээмжтэй, уялдаа холбоотой нэгдсэн байх нөхцөлийг бүрдүүлэх, газар зүйн зорилтот хөтөлбөрүүдийн сайн туршлагыг ашиглах;
3. НҮБ-ын Удирдлагын баг болон Засгийн газар нь НҮБ-ын ТХХАХ-г стратегийн түвшинд хянаж, удирдахын тулд үр дүнд суурилсан удирдлага, хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх;
4. НҮБ-ын Удирдлагын баг, Үндэсний статистикийн хороо болон салбарын яамд хамтран нарийвчилсан задаргаа бүхий мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, түгээх, ашиглах үндэсний чадавхыг сайжруулах шаардлагатай. Ингэснээр ТХЗ-ын хэрэгжилт болон дараагийн НҮБ-ын ТХХАХ-ний хэрэгжилтэд хяналт тавих нөхцөл бүрдэнэ.
5. НҮБ-ын Удирдлагын баг болон Засгийн газар нь НҮБ-ын ТХХАХ-ний тогтвортой байдлыг бэхжүүлэхэд анхаарах;
6. НҮБ-ын Удирдлагын баг нь хөрөнгө санхүүгийн гүйлгээний зардлыг бууруулахад чиглэсэн бүхий л хүчин чармайлтаа үргэлжлүүлэх шаардлагаг байна.

2.6 САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГИЙН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭЛТ

2.6.1 Санхүүжилт, зарцуулалт

Хүснэгт 1. НҮБХТХ-ний санхүүжилт

НҮБ-ын системийн байгууллага	НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ	Шаардлагатай		Нийт бэлэн байгаа		Босгох	Зарцуулалт					
		Амлалт	Нийт	Нийт	Үндсэн		Үндсэн бус	2017	2018	2019	2020	2021
НИЙТ	79,670,034	198,767,513	191,329,408	20,868,298	155,595,434	7,438,105	22,828,611	22,326,988	24,713,475	40,397,123	52,837,772	163,103,968
Үр дүн 1 Нийт	34,199,242	98,472,264	94,950,961	-	80,085,283	3,521,304	12,494,118	11,690,581	11,772,192	24,412,939	18,116,955	78,486,785
1 НҮБ-ын ХХААБ	3,700,000	11,128,767	11,128,767	1,932,578	9,196,189	-	4,352,692	1,601,235	1,927,343	2,112,458	991,151	10,984,879
2 ОУАЭА	1,400,000	2,346,063	2,315,563		2,315,563	30,500	-	66,452	74,326	1,000,966	1,058,707	2,200,451
3 ОУХБ	750,000	1,391,830	1,342,840	1,171,767	171,073	48,990	434,962	181,428	255,335	189,278	371,074	1,432,077
4 ОУШХБ		3,932,163	3,925,265	1,589,000	2,336,265	6,898	400,224	691,090	506,871	897,572	334,097	2,829,853
5 НҮБ-ын ОБХАХ		15,000	15,000	15,000	-	-				13,000		13,000
6 НҮБ-ын ХС	100,000	6,570,858	6,323,841	2,998,521	3,325,320	247,017	220,752	604,177	1,365,224	1,553,112	1,421,276	5,164,541
7 НҮБ-ын ХХ	20,000,000	25,530,230	25,456,861	3,262,912	22,193,949	73,369	3,886,805	2,879,921	2,485,021	3,647,383	4,541,732	17,440,861
8 НҮБ-ын АНДЭЭНК		248,890	248,890		248,890	-			-	164,345	84,545	248,890
9 НҮБ-ын БШУСБ	322,000	800,122	665,712	427,149	238,563	134,410	0	52,000	75,000	425,063	63,000	615,063
10 НҮБ-ын БОХ	1,500,000	5,787,651	4,829,766		4,829,766	957,885	313,863	371,200	865,275	1,733,293	1,004,981	4,288,612
11 НҮБ-ын ХАСХ	100,000	3,968,576	3,968,576		3,968,576	-	95,167	86,300	985,662	1,825,119	976,328	3,968,576
12 НҮБ-ын АУХБ	2,277,242	22,294,977	20,272,742		20,272,742	2,022,235	2,789,654	5,156,778	908,485	4,187,545	4,765	13,047,227
13 ДХХ		323,215	323,215		323,215	-	-	-	195,708	127,507		323,215
14 ДЭМБ	4,050,000	14,133,922	14,133,922	3,468,751	10,665,171	-	-	-	2,127,942	6,536,299	7,265,299	15,929,540

Үр дүн 2 Нийт	37,855,792	71,661,862	68,443,054	14,506,887	53,936,167	3,218,808	6,023,160	6,268,388	8,109,424	10,686,712	29,542,071	60,629,754
1 НҮБ-ын ХХААБ		4,713,828	4,713,828	1,182,736	3,531,092	-	164,572	148,675	340,001	875,613	860,628	2,389,489
2 ОУАЭА	1,700,000	1,371,642	1,292,455		1,292,455	79,187	6,376	748,421	386,354	73,981		1,215,132
3 ОУХБ	750,000	467,420	467,420	19,011	448,409	-	17,815.00	1,196.00		292,226.00	366,763.00	678,000
4 ОУШХБ		1,151,669	1,080,269		1,080,269	71,400			54,454.30	358,000.70	398,093.00	810,548
5 НҮБ-ын ХС	18,513,227	40,831,468	37,763,246	2,361,537	35,401,709	3,068,221	1,850,282	1,855,625	3,325,432	5,513,564	23,170,474	35,715,377
6 НҮБ-ын БШУСБ	300,000	1,495,000	1,495,000	1,205,000	290,000	-	110,000	180,000	340,000	650,000	275,744	1,555,744
7 НҮБ-ын ХАСХ	100,000	1,000,000	1,000,000	0	1,000,000	-				200,000	400,000	600,000
8 НҮБ-ын ДОХ/ХДВ-н ХХ		24,232	24,232	24,232	-	-	24,232					24,232
9 НҮБ-ын ХАС	9,300,000	9,065,589	9,065,589	1,538,947	7,526,642	-	931,283	1,705,872	2,255,182	2,278,523	1,617,324	8,788,184
10 ДЭМБ	7,192,565	11,541,014	11,541,014	8,175,424	3,365,590	-	2,918,600	1,628,599	1,408,000	444,805	2,453,045	8,853,049

Үр дүн 3 Нийт	7,615,000	28,633,387	27,935,394	6,361,411	21,573,984	697,993	4,311,333	4,368,019	4,831,860	5,297,471	5,178,746	23,987,428
1 ОУХБ	1,000,000	898,385	898,385	514,916	383,469	-	35,000.00	89,322.00	151,041.00	124,828.00	151,693.00	551,884
2 ОУШХБ		1,453,040	1,453,040		1,453,040	-	189,579.20	139,965.20	2,100.00	777,372.00	389,505.00	1,498,521
3 НҮБ-ын ХС	450,000	3,374,827	2,839,137	749,216	2,089,921	535,690	333,701.00	418,605.00	468,030.00	887,595.99	690,440.00	2,798,372
4 НҮБ-ын ХХ	750,000	11,091,302	11,090,075	560,000	10,530,075	1,227	1,033,522.53	1,880,285.00	2,065,814.52	1,492,962.43	2,357,328.00	8,829,912
5 НҮБ-ын БШУСБ	365,000	180,854	180,854		180,854	-	0.00	0.00	0.00	0.00	65,360.00	65,360
6 НҮБ-ын ХАСХ		338,760	338,760		338,760	-	148,320.00	190,440.00				338,760
7 НҮБ-ын ХАС	5,000,000	11,244,128	11,108,163	4,510,298	6,597,865	135,965	2,562,949.92	1,645,921.84	2,106,614.00	2,014,712.60	1,524,420.00	9,854,618
8 ДЭМБ	50,000	52,090	26,980	26,980	-	25,110	8,260.00	3,480.00	38,260.00			50,000




2.7.2 Хөрөнгийн татан төвлөрүүлэлт

НҮБ-ын системийн байгууллагууд санхүүжилтийн 84 төрлийн эх үүсвэрээс нийт 191,3 сая ам.долларын хөрөнгийг


татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувийн жинг санхүүжилтийн эх үүсвэрээр дараах Зураг 2.7.2.1-т үзүүлэв.

НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын нийт зарцуулалт, 2017-2021 онуудад




Зураг 2.7.2.1: 2017-2021 онд татан төвлөрүүлсэн нийт хөрөнгө

2017-2021 оны хооронд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө



Зураг 2.7.2.2: Татан төвлөрүүлсэн нийт хөрөнгө, үр дүнгийн зорилтоор

2017-2021 оны хооронд нийт татан төвлөрүүлсэн санхүүжилт - үр дүнгээр (сая ам.доллар)



Зураг 2.7.2.3. НҮБ-ын системийн байгууллагуудын нийт зарцуулалт, 2017-2021

НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГИЙН ИРЭХ ЖИЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

3 БҮЛЭГ

НҮБ нь 2022 онд дараах асуудалд гол анхаарлаа чиглүүлнэ. Үүнд:

- ТХЗ-ыг хэрэгжүүлэх, ялангуяа хөдөө орон нутагт ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглүүлж иргэнийнийгмийн байгууллагуудын чадавхи, үйл ажиллагаа, сургалт сурталчилгааны ажлыг сайжруулах;
- Бүс нутгийн хөгжлийг сайжруулахын тулд нэгдмэл бодлого, зорхицуулалттай байх, бүх нийтийн оролцоог хангаж цогц байх зарчмыг баримталж дэмжих;
- Төрийн үйлчилгээ хүргэгчдийн чадавхийг бэхжүүлж, хүн амын орхигдох эрсдэлтэй нэн эмзэг бүлгийн төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах;
- ТХЗ-ын санхүүжилт болон төсвийн төлөвлөлтийн үйл явцыг хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулж, хүн амын нэн эмзэг бүлгүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх;
- Компаниудад тогтвортой байдлын тайлан гаргах дадлыг сурталчлан таниулж хэвшүүлэх, ногоон хөрөнгө оруулалтын боломжуудыг тодорхойлох замаар тогтвортой хөгжлийг дэмжих;
- НҮБ-ын төсөл хөтөлбөрүүдэд иновацийг нэвтрүүлж, хүн амын нэн эмзэг бүлгүүдийн тоон бичиг үсгийн мэдлэгийг дээшлүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Монгол Улсын Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг дэмжих байгаль орчинд ээлтэй технологи, туршлагыг нэвтрүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээлэлд суурилсан байгалийн нөөцийн менежментийг тогтвортой мал аж ахуйн менежментийн арга туршлагатай хослуулан сайжруулах замаар малчдын эрсдлийг даах чадавхийг бэхжүүлэх;
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах механизмын чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- 2021 онд шинээр батлагдсан хууль, тогтоомжийг хамруулсан Монгол Улсын эрх зүйн шинэчлэлд хувь нэмэр оруулах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх;
- Шийдвэр гаргах түвшин дэх залуучууд, эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор залуучууд, эмэгтэйчүүдийн сүлжээг бэхжүүлж, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- КОВИД-19-ын цар тахлаас сургамж авч болзошгүй хямралтай тэмцэх бэлэн байдлын чадавхийг бүх түвшинд бий болгох;
- Хамгийн удаашралтай байгаа ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын хөтөлбөрүүдтэй хослуулж цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан хоол тэжээлийн боловсролын багцыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
- Хөгжлийн бодлого боловсруулах, ялангуяа хууль тогтоомж, бодлого төлөвлөлтийг боловсруулж хэрэгжүүлэхэд шаардагдах тоо мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг дэмжих;
- НҮБХТХ-ний үнэлгээний зөвлөмжийн дагуу удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх зэрэг болно.

ХАВСРАЛТ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ГЭБ	Гамшгийн эрсдэлийг бууруулах
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ИТХ	Иргэдийн төлөлөөгчдийн хурал
КОВИД-19	Коронавируст халдвар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮБ-ын МХБ	НҮБ-ын мэдээл харилцааны баг
НҮБ-ын ТХХАХ	НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ
НҮБ-ын ХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБ-ын ХС	НҮБ-ын Хүүхдийн сан
НҮБ-ын ХТХ	НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ
НҮБ-ын ХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБ-ын ХХААБ	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төвүүд
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ОХУ	Оросын Холбоот Улс
ӨБХТ	Өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөгөө
ПГУ	Полимеразын гинжин урвал
ТАЗ/CSC	Төрийн албаны зөвлөл
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХҮЗ	Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл
ТХОТЗ	Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөл
ТХҮХ	Тогтвортой хөгжлийн үндэсний хороо
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
УИХ	Улсын их хурал
ҮНСС	Үндэсний нэгдсэн санхүүжилтийн стратеги
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЭАБХУК	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц
ЭМС	Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



НЭГДСЭН
ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



-  /unmongolia
-  /unmongolia
-  mongolia.un.org
-  unrcmongolia@un.org
-  (976)11-32 75 85